Ёс зүйн хорооны 2025 оны ... дүгээр
сарын ...-ний өдрийн ... дугаар тогтоолын
гуравдугаар хавсралт

ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН 2025 ОНЫ ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН "ТАЙЛАНГИЙН МАЯГТ"[1]

НЭГ. Товч танилцуулга
Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын даргын Салбарын ёс зүйн дэд хороо байгуулах тухай 2024 оны А/276 дугаар тушаал, Тушаалд өөрчлөлт оруулж, ёс зүйн дэд хорооны даргаар томилох тухай 2025 оны А/360 дугаар тушаал, Ёс зүйн дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай 2025 оны А/361 дүгээр тушаалаар тус тус Ёс зүйн дэд хороог шинэчлэн байгуулсан. Монгол Улсын Ёс зүйн хорооны 2024 оны 05 дугаар тогтоолоор баталсан "Ёс зүйн дэд хорооны ажиллах журам"-ын 2.4-т заасны дагуу Ёс зүйн дэд хороо нь 7 гишүүнтэй ба Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2 дахь хэсэгт заасны дагуу байгууллагын нийт албан хаагчдын санал хураалтаас олонхын дэмжлэг авсан 7 гишүүнийг сонгон томилсон. Салбар байгууллагын хэмжээнд 21 аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар болон Нийслэлийн Газар зохион байгуулалтын албанд нийт 1040 албан хаагчийг төлөөлж, 3 гишүүнтэй 9, 5 гишүүнтэй 12, 7 гишүүнтэй 1, 22 Ёс зүйн дэд хороонд 94 албан хаагч ажиллаж байна. Салбарын хэмжээнд нийт 23 Ёс зүйн дэд хороонд 101 албан хаагч ажиллаж байна. Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын Ёс зүйн дэд хорооны 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг Төрийн албан хаагчийг ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилтын хүрээнд 7, Албан хаагчийг ёс зүйн зөрчилтэй холбоотой гомдол, мэдээллийг хянан шалгах, дүгнэлт гаргах, тайлагнах зорилтын хүрээнд 4, Ёс зүйн дэд хорооны зохион байгуулалт, үйл ажиллагааны хүрээнд 3 арга хэмжээг тусгаж 2025 оны 01 дүгээр сарын 20-нд батлуулж, хэрэгжилтийг ханган ажилласан.
ХОЁР. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар
2.1.Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт[2]:
Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газар, 21 аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар болон нийслэлийн Газар зохион байгуулалтын албаны Ёс зүйн дэд хороо нь Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Төрийн албан хаагчийг ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр идэвхтэй ажилласан байна. Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн Төрийн албанд ёс зүйн зөрчлийг үл тэвчих сэтгэлгээ, шударга байдлыг эрхэмлэхэд чиглэсэн соён гэгээрүүлэх ажлыг эрчимжүүлэх зорилтын хүрээнд байгууллага төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомжийг мөрдүүлж, ёс зүйтэй, шударга ажиллах талаар ойлголт, хандлага, соёлын өөрчлөлт бий болгоход чиглэсэн ажлын байран дахь сургалтыг тогтмол зохион байгуулан ажилласан. Үүнд. - Ёс зүй, ашиг сонирхлын зөрчил, сахилга хариуцлагын сэдвээр салбарын хэмжээнд нийт 53 удаагийн сургалт, мэдээллийн арга хэмжээ зохион байгуулсан. - Давхардсан тоогоор 830 гаруй албан хаагчид танхимаар болон цахимаар хамрагдсан.

[1] Маягтын дагуу тайланг 5 хуудаснаас ихгүй, товч үр дүнг нэгтгэн ирүүлнэ.

[2] Улсын Их Хурлын 2024 оны 27 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх хүрээнд зохион байгуулсан үйл ажиллагааны талаар тайлагнана.

Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ, үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэх явцдаа , ёс зүйн зөрчилөөс ангид байх, харилцаа хандлагыг дээшлүүлэх талаар салбар байгууллагын дотоод хүний нөөц болон мэргэжлийн байгууллагуудтай хамтран тус сургалт, арга хэмжээг зохион байгуулсан.

Төрийн албан хаагч ёс зүйтэй ажиллахад дэмжлэг үзүүлэх сургалт, нөлөөллийн ажлыг идэвхжүүлэх арга хэмжээний хүрээнд 11 салбар байгууллагын хэмжээнд нөлөөллийн ажлыг зохион байгуулсан. Тухайлбал, Дэлхийн ёс зүйн өдрийг тохиолдуудлан 2025 оны 10 дугаар сарын 13-17-ны өдрүүдэд "Авлига, ашиг сонирхлын зөрчилгүй, ёс зүйтэй хамт олон" аяныг зохион байгуулсан. "Нэргүй захидал" элдэгээр бусдын харилцаа, хандлагатай холбоотой санал өгөх хайрцгийг аялуулах, Талархлын мод арга хэмжээг зохион байгуулж, эерэг зан чанарыг нь ойлгуулах, Хүндэлье-Энэрье аяныг өрнүүлэх, Өмнөговь, Говьсүмбэр аймгын Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газарт нийт албан хаагчдын дунд санал асуулга явуулж "ёс зүйтэй", "хариуцлагатай", "ур чадвартай" албан хаагчдыг шалгаруулж, бусдад үлгэрлэх зэрэг нөлөөллийн ажлыг зохион байгуулж, нийт албан хаагчдыг идэвхтэй хамруулсан байна.

Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг удирдамж зааврааар хангаж, зохион байгуулалтыг сайжруулах зорилтын хүрээнд зарим аймгуудад ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлтэй гэж үнэлэгдсэн албан тушаал эрхэлдэг албан хаагч ёс зүйн нөлөөллийн мэдүүлэг гаргах ажлыг зохион байгуулсан. Баян-Өлгий аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газарт эрсдэлд өртөж болох нөхцөл байдлыг сануулан нөлөөллийн мэдүүлэг баталгаажуулснаар албан хаагчдын дунд өөртөө дүгнэлт хийх, харилцаа, хандлагатай анхаарах зэрэг эерэг байдал ажиглагдсан.

2.2.Томилох эрх бүхий албан тушаалтны ёс зүйн манлайлал:

Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газар, 21 аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар болон нийслэлийн Газар зохион байгуулалтын албаны дарга нь Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, байгууллагын хэмжээнд ёс зүй, хариуцлага нэмэгдүүлэх чиглэлээр сургалт зохион байгуулах, нөлөөллийн аян өрнүүлэх болон бусад холбогдох чиглэлд Ёс зүйн дэд хороодтой хамтран ажиллаж байна. Ёс зүйн хорооны 2025 оны 09 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлагдсан "Ёс зүй, сахилга, хариуцлагын үнэлгээний шалгуур үзүүлэлт"-ийн дагуу Ёс зүйн дэд хорооны дүгнэлтийг үндэслэн томилох эрх бүхий этгээд шийдвэр гаргасан. Үүнд. Салбар байгууллагын хэмжээнд Ёс зүйн зөрчил гаргасан 2 дүгнэлтийн дагуу Сүхбаатар аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын 2 албан хаагчид ёс зүйн хариуцлага хүлээлгэсэн. Баян-Өлгийн аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын 1 албан хаагчид сахилгын шийтгэл оногдуулсан.

Салбарын 18 Ёс зүйн дэд хороод Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайлан болон холбогдох мэдээг байгууллагын цахим хуудсанд ил тод байршуулан ажилласан.

Салбарын нийт 23 Ёс зүйн дэд хорооны 6 дэд хороо (Баян-Өлгий, Говьсүмбэр, Дорноговь, Дундговь, Увс, Хэнтий аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар)-нд хамаарах 22 албан хаагч Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 13.4.1 дэх хэсэг, Ёс зүйн хорооны 2024 оны 05 дугаар тогтоолоор батлагдсан Ёс зүйн дэд хороо ажиллах журмын 3.7, 3.8 дэх хэсэгт тус тус заасан урамшуулалыг 2025 онд авсан. Салбарын үлдсэн 17 Ёс зүйн дэд хорооны дарга, гишүүн, нарийн бичгийн даргаар ажиллаж байгаа 79 албан хаагчид 2025 онд төсвийн санхүүжилт хязгаарлагдмал тул урамшуулал олгоогүй байна.

2.3. Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа:

Тус газрын салбар 23 байгууллагууд Ёс зүйн дэд хороод байгуулсан бөгөөд Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2 дахь хэсэгт заасны дагуу байгууллагын нийт албан хаагчдын санал хураалтаас олонхын дэмжлэг авсан албан хаагчдыг сонгож, Ёс зүйн дэд хороо ажиллах журмын 2.4 дэх хэсэг "40 ба түүнээс цөөн төрийн албан хаагчтай байгууллагын дэргэдэх Ёс зүйн дэд хороо нь 3 гишүүн, 41–90 бол 5 гишүүн, 91-ээс дээш бол 7 гишүүнтэй байна" гэж заасныг тус тус үндэслэл болгосон. Салбарын Ёс зүйн дэд хороодын бүрэлдэхүүнд орсон өөрчлөлт, хөдөлгөөнийг тухай бүр бүртгэн ажилласан.

Салбарын хэмжээнд Төрийн албан хаагчаас болон иргэнээс Төрийн албан хаагчийн ёс зүй, харилцаа, хандлагатай холбоотой ирүүлсэн гомдол, мэдээллийг шалгаж, нийт 13 өргөдөлд дүгнэлт үйлдэж, томилох эрх бүхий албан хаагчид хүргүүлсэн. Салбар байгууллагын хэмжээнд Ёс зүйн зөрчлийн бүртгэл, хяналтын дэд систем дэх дүгнэлт, шийдвэрийг бүртгэж ажилласан бөгөөд тухайн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөө, түүний биелэлтийг оруулж ажиласан байна.	
Гарсан үр дүн, ололт амжилт:	Бэрхшээл:
-Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ, ёс зүйн зөрчлөөс ангид байх, ашиг сонирхлын зөрчил, сахилга хариуцлага, харилцаа, хандлага холбоотой салбарын хэмжээнд нийт 53 удаагийн сургалт, мэдээллийн арга хэмжээ зохион байгуулж, давхардсан тоогоор 830 гаруй албан хаагчид танхимаар болон цахимаар хамрагдсан.	Салбар байгууллагаас хамгийн олон ирүүлсэн саналыг нэгтгэн тайлагнав. Үүнд: - Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг байгууллагын дотоод нөөц боломжоор сургалт зохион байгуулж, сурталчлан таниулж байгаа бөгөөд Ёс зүйн зөрчлөөс ангид байх, соён гэгээрүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх сургалт, аян, танилцуулга материал, арга хэмжээнд төсөв хүрэлцдэггүй, зарим тохиолдолд төсөв байдаггүй.
- 11 салбар байгууллагын хэмжээнд хэрэгжсэн нөлөөллийн аянууд эерэг нөлөө үзүүлсэн. "Нэргүй захидал" эелдэгээр бусдын харилцаа, хандлагатай холбоотой санал өгөх хайрцгийг аялуулснаар өөрийн харилцаа, хандлага, ёс зүйд дүгнэлт хийх, Талархлын мод арга хэмжээг зохион байгуулж, эерэг зан чанарыг нь өөрт нь ойлгуулах зэрэг нөлөөллийн ажлууд цаашид эрчимжих хандлагатай байна.	- Төсвийн хэмнэлт, санхүүжилт хязгаарлагдмал байдлаас үүдэн ихэнх Ёс зүйн дэд хороодын гишүүдэд урамшуулал олгоддоггүй;
- Ёс зүйн дэд хороодын гишүүд өөрсдийн Ёс зүй, хүний эрх, төрийн албаны манлайлал зэрэг чиглэлээр мэдлэг, ур чадварыг тогтмол дээшлүүлж байна. Тухайлбал, Дорнод аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Ёс зүйн дэд хорооны гишүүд "Ёс зүй" 1, 2, 3 дугаар түвшний цахим сургалтад хамрагдаж гэрчилгээ авсан, нийслэлийн Газар зохион байгуулалтын албаны Ёс зүйн дэд хорооны нарийн бичгийн дарга Ёс зүйн сургагч багш болсон.	-Ёс зүйн хорооноос баталсан аргачлалын дагуу байгууллага, албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдлийг тооцох үнэлгээг хийхэд мэргэжил, арга зүйн зөвлөгөө дутмаг
Санал: - Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг байгууллагын дотоод нөөц боломжоор сургалт зохион байгуулж, сурталчлан таниулж байгаа бөгөөд Ёс зүйн зөрчлөөс ангид байх, соён гэгээрүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх сургалт, аян, танилцуулга материал, арга хэмжээнд зориулан төсөв хуваарилж байх; - Ёс зүйн дэд хороодын дарга, гишүүн, нарийн бичгийн даргаар ажиллаж байгаа албан хаагчдад Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 13.4.1 дэх хэсэг, Ёс зүйн хорооны 2024 оны 05 дугаар тогтоолоор батлагдсан Ёс зүйн дэд хороо ажиллах журмын 3.7, 3.8 дэх хэсэгт тус тус заасан урамшуулалыг олгох;	

- Ёс зүйн хорооноос Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хүрээнд байгууллага албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдлийг тооцох үнэлгээ чиглэлээр хагас жил тутамд сургалт зохион байгуулж, Ёс зүйн дэд хороодод шинээр томилогдсон болон гишүүдийг хамруулж байх;

- Ёс зүйн зөрчлийн бүртгэл, хяналтын дэд системд биелэлт оруулах үед 100 хүртэлх тэмдэгттэй байгаа нь зарим тохиолдолд бүрэн тайлагнахад дутагдалтай.

Шалгах хэсэг:

☑ "Ёс зүй, сахилга хариуцлагын үнэлгээний шалгуур үзүүлэлт"-ийн дагуу үнэлгээ хийсэн эсэх.

☑ Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтэд нийцүүлэн баталсан үйл ажиллагааны төлөвлөгөө хавсаргасан эсэх.

☑ Байгууллагын 2025 оны Ёс зүйн дэд хорооны хууль тогтоомжийн хэрэгжилтийн тайланг маягтын дагуу бүрэн тайлагнасан эсэх.

БАТАЛГААЖУУЛАЛТ:

Томилох эрх бүхий албан тушаалтан

Дарга
/Албан тушаал/ */Гарын үсэг/* А.Энхманлай */Гарын үсгийн тайлал/*

Ёс зүйн дэд хорооны дарга

Төрийн захиргаа удирдлагын
газрын даргын албан үүргийг
түр орлон гүйцэтгэгч

/Албан тушаал/ */Гарын үсэг/* Б.Энхболд */Гарын үсгийн тайлал/*

Ёс зүйн дэд хорооны нарийн бичгийн дарга

Мэдээлэл, технологийн хэлтсийн
даргын албан үүргийг
түр орлон гүйцэтгэгч

/Албан тушаал/ */Гарын үсэг/* А.Уянга */Гарын үсгийн тайлал/*

Огноо: ..... оны ..... сарын .....

БАТЛАВ
ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ГЕОДЕЗИ,
ЗУРАГ ЗҮЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ЁС ЗҮЙН
ДЭД ХОРООНЫ ДАРГА
А.АМАРСАЙХАН

2025 оны 01 дүгээр сарын 20

ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ 2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

2025.01.06 Улаанбаатар хот

№	Үйл ажиллагаа	Хугацаа	Хүрэх түвшин, үр дүн	Хариуцах гишүүн
	Нэг. “Төрийн албан хаагчийг ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх Үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх зорилтын хүрээнд:			
1	Ёс зүйн хэм хэмжээг сахих, мөрдөн ажиллахтай холбоотой сургалтын материал бэлдэх, сургалтын төлөвлөгөө гаргах	1 дүгээр улирал	Сургалтын бэлтгэл хангагдсан байна.	Ёс зүйн дэд хороо
2	Ёс зүйн хороотой хамтран Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх уулзалтыг зохион байгуулах	1 дүгээр улирал	Уулзалт зохион байгуулсан байна.	Ёс зүйн дэд хорооны дарга
3	Ерөнхий газрын нийт албан хаагчид болон орон нутгийн газрын харилцааны удирдах ажилтнуудад зориулсан ёс зүйн танхимын болон цахим сургалтыг зохион байгуулах	Хагас жил тутамд	2 удаагийн сургалтыг зохион байгуулсан байна.	Ёс зүйн дэд хороо
4	Ерөнхий газарт шинээр томилогдсон албан хаагчдад ёс зүйн хууль тогтоомжийг танилцуулах, зөвлөмж өгөх	Тухай бүр	Шинээр томилогдсон албан хаагч бүрт нэг удаа зөвлөмж өгсөн байна.	Ёс зүйн дэд хороо
5	Ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр зөвлөмж боловсруулах, байгууллагын албан хаагчид болон орон нутагт хүргүүлэх	1 дүгээр улирал	Зөвлөмжийн цахим хэлбэрээр түгээсэн байна.	Ёс зүйн дэд хороо
6	Салбарын хэмжээнд үүсэж болзошгүй ёс зүйн зөрчил, түүний шалтгаан, эрсдэлийг тодорхойлон, дүн шинжилгээ хийх, байгууллагын удирдлагад танилцуулах	1 дүгээр улирал	Судалгаа шинжилгээний дүнг байгууллагын удирдлагад танилцуулсан байна.	Ёс зүйн дэд хороо

7	Албан хаагчдад төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, журмын талаар гарын авлага, тараах материал бэлтгэн хэвлүүлэх	1 дүгээр улирал	Гарын авлага боловсруулан бэлтгэж, хэвлүүлсэн байна.	Ёс зүйн дэд хороо
	Хоёр. Албан хаагчийн ёс зүйн зөрчилтэй холбоотой талаарх гомдол, мэдээллийг хянан шалгах, дүгнэлт гаргах, тайлагнах зорилтын хүрээнд:			
1	Туршилтын хугацаанд ажилласан албан хаагчдад холбогдох хууль тогтоомжийн дагуу дүгнэлт гаргах	Тухай бүр	Дүгнэлт гарсан байна.	Ёс зүйн дэд хороо
2	Ёс зүйн зөрчлийн талаарх гомдол, мэдээллийг хүлээн авах, хянаж шалган дүгнэлт, зөвлөмж гаргах	Тухай бүр	Хурлын тэмдэглэл, дүгнэлт гарсан байна.	Ёс зүйн дэд хороо
3	Ёс зүйн зөрчлийн талаарх гомдол мэдээлэл, холбогдох хурлын тэмдэглэл, шийдвэрийн бүрдлийг ханган архивлах, Төрийн албаны цахим системд оруулах	1 дүгээр улирал	Холбогдох журмын архивлагдсан байна.	Ёс зүйн дэд хорооны нарийн бичгийн дарга
4	Дэд хорооны үйл ажиллагааг байгууллагын цахим хуудсаар сурталчлах, тайлагнах, тайланг Ёс зүйн хороонд хүргүүлэх	Улирал бүр	Үйл ажиллагааны мэдээллийг тухай бүр мэдээлж, тайланг хагас, бүтэн жилээр тайлагнасан байна.	Ёс зүйн дэд хорооны дарга, нарийн бичгийн дарга
	Гурав. Ёс зүйн дэд хорооны зохион байгуулалт, үйл ажиллагааны хүрээнд:			
1	Ёс зүйн дэд хорооны төлөвлөгөө боловсруулах, батлах	1 дүгээр сар	Төлөвлөгөө батлагдсан байна.	Ёс зүйн дэд хороо
2	Ёс зүйн дэд хорооны хэвлэмэл хуудсыг хэвлүүлэх, үйл ажиллагаанд шаардагдах бичиг хэргийн зардлын тооцоог гаргаж батлуулах	1 дүгээр улирал	Хэвлэмэл хуудсыг хэвлүүлж, бичиг хэргийн зардлыг батлуулсан байна.	Ёс зүйн дэд хорооны нарийн бичгийн дарга
3	Ёс зүйн дэд хорооны хурлыг зохион байгуулах	Жилдээ	Хурлыг зохион байгуулсан байна.	Ёс зүйн дэд хорооны дарга, нарийн бичгийн дарга

ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛСАН:

ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА: Л.МАНДХАЙ

Ёс зүйн хорооны 2025 оны ... дугаар
сарын ...-ний өдрийн ... дугаар тогтоолын
нэгдүгээр хавсралт

ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН 2025 ОНЫ
“ЁС ЗҮЙ, САХИЛГА ХАРИУЦЛАГЫН ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ”

№	Үзүүлэлт	Шалгуур үзүүлэлт		Авбал зохих оноо	Оноо[1]	Хувийн жин[2]
1	2	3		4	5	6
1	Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт[3] (ҮХХ)	Үйл ажиллагааны төлөвлөгөөг шалгуур үзүүлэлттэй нийцүүлэн батлагдсан эсэх[4]		1	1	10
2		Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийн үнэлгээ хийсэн эсэх [5]		1	0.8	8
3		Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлсэн байдал	Ёс зүйн сургалтыг 2-оос доошгүй удаа батлагдсан агуулгын хүрээнд зохион байгуулсан эсэх [6]	0,5	0.4	4
			Соён, гэгээрүүлэх нөлөөллийн ажил зохион байгуулсан байдал[7]	0,5	0.4	4
			Ёс зүйн нөлөөллийн мэдүүлэг гаргасан байдал[8]	0,5	0.3	3
			Ёс зүйн зөрчлийн хариуцлагын бүртгэлийн маягт бөглөсөн байдал[9]	0,5	0.3	3
Хэсгийн оноо				**4**	**3.2**	**32**
4	Томилох эрх бүхий албан тушаалтны ёс зүйн манлайлал (ЁЗМ)	Ёс зүйн дэд хорооны дүгнэлтийг үндэслэн шийдвэр гаргасан эсэх [10] (*гарсан дүгнэлтийн хувийн жингээр тооцох бөгөөд гомдол ирээгүй бол 1 оноо)*		1	1	10
5		Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайлан, зөрчлийн шийдвэрлэлтийг цахим хуудсанд байршуулсан байдал[11]		1	0.9	9
6		Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа, гишүүдийг урамшуулах санхүүгийн эх үүсвэрийг шийдвэрлэсэн байдал[12]		1	0.4	4
Хэсгийн оноо				**3**	**2.3**	**23**
7	Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа (ЁЗДХ)	Дэд хорооны бүрэлдэхүүн хөдөлгөөнийг бүртгэсэн байдал[13]		1	1	10
8		Төрийн албан хаагчаас ирүүлсэн гомдол, мэдээллийг шийдвэрлэсэн байдал [14] *(Гомдол ирээгүй бол 1 оноо авна, нийт ирүүлсэн өргөдөл, гомдлын хувийн жингээр тооцно)*		1	0.9	9
9		Ёс зүйн зөрчлийн бүртгэл, хяналтын дэд систем дэх дүгнэлт, шийдвэрийг бүртгэж, тайлагнасан байдал [15]		1	1	10
Хэсгийн оноо				**3**	**2.9**	**29**
Үнэлгээний нийт оноо, хувь				**10**	**8.4**	**84**

$$\text{Эзлэх хувь} = \frac{\text{ҮХХ} + \text{ЁЗМ} + \text{ЁЗДХ}}{10} * 100\%$$

Тайлбар:
[1] Байгууллагын өөрийн болон харьяа, салбар байгууллагад өгсөн үнэлгээ.
[2] Авсан оноог 10-аар үржиж хувийн жинг тооцох ба нийт дүн 100-с хэтрэхгүй байна.
[3] УИХ-ын 2024 оны 27 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр”.

[4] ЁЗХ-ны 2025 оны 04 дүгээр тогтоолоор батлагдсан “Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт”-д нийцүүлэн батлагдсан төлөвлөгөөг хавсарган ирүүлнэ.

[5] ЁЗХ-ны 2025 оны 06 дугаар "Аргачлал батлах тухай" тогтоол.

[6] УИХ-ын 2024 оны 27 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр”-ийн 2.1 дэх хэсэг, ЁЗХ-ны 2024 оны 05 дугаар тогтоолоор батлагдсан "Ёс зүйн дэд хорооны ажиллах журам"-ын 4.1.3, мөн оны 15 дугаар “Сургалтын агуулга, сэдэв батлах тухай” тогтоол.

[7] Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.3 дахь заалт.
[8] ЁЗХ-ны 2025 оны 06 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлагдсан “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийг тооцох үнэлгээний аргачлал”-ын 8.3.3, мөн оны 07 дугаар "Ёс зүйн нөлөөллийн мэдүүлэг гаргах, шалган шийдвэрлэх талаар авах арга хэмжээний тухай" тогтоол.

[9]ЁЗХ-ны 2024 оны 13 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлагдсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил, тэдгээрт хүлээлгэсэн хариуцлагын бүртгэлийг хөтлөх, мэдээллийн цахим санг удирдах, хөгжүүлэх, ёс зүйн зөрчлийн талаар олон нийтэд мэдээлэх журам”-ын 3.8 дахь хэсэг, 2025 оны 08 дугаар "Загвар батлах тухай" тогтоол.

[10] Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.5 дахь заалт.
[11] Мөн хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсэг.
[12] Мөн хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.3 дахь заалт.
[13] ЁЗХ-ны 2024 оны 13 тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлагдсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил, тэдгээрт хүлээлгэсэн хариуцлагын бүртгэлийг хөтлөх, мэдээллийн цахим санг удирдах, хөгжүүлэх, ёс зүйн зөрчлийн талаар олон нийтэд мэдээлэх журам”-ын 4.2.2 дахь заалт.

[14] Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3.1 дэх заалт.
[15] ЁЗХ-ны 2024 оны 13 тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлагдсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил, тэдгээрт хүлээлгэсэн хариуцлагын бүртгэлийг хөтлөх, мэдээллийн цахим санг удирдах, хөгжүүлэх, ёс зүйн зөрчлийн талаар олон нийтэд мэдээлэх журам”-ын 4.4.3, 4.4.4 дэх заалт.

-oOo-

ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ГЕОДЕЗИ,
ЗУРАГ ЗҮЙН ЕРӨНХИЙ ГАЗАР
АРХАНГАЙ АЙМАГ
**ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА,
ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗАР**

Дэмид жанжны 3-300 тоот, 1 дүгээр баг,
Эрдэнэбулган сум, Архангай аймаг, 65141
Утас: (976) 7033 3632, 7033-3633
Цахим шуудан: arkhangai@gazar.gov.mn
Цахим хуудас: www.arkhangai.gazar.gov.mn

2025.12.30. № 1062

танай _____-ны №_____-т

ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ТӨРИЙН ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ГАЗРЫН ДАРГА Б.ЭНХБОЛД ТАНАА

ГЗБГЗЗЕГ-ын ирүүлсэн 2025 оны 2/4046 дугаартай албан бичгийн дагуу тус газрын 2025 оны төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулсан тайланг хавсралтаар хүргүүлэв.

Хавсралт..... хуудастай

ДАРГА Ч.ОТГОНЖАРГАЛ

Ёс зүйн хорооны 2025 оны 12 дугаар
сарын 01-ний өдрийн 09 дүгээр тогтоолын
гуравдугаар хавсралт

АРХАНГАЙ АЙМГИЙН ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ 2025 ОНД ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ХҮРЭЭНД ХИЙЖ ХЭРЭГЖҮҮЛСЭН АЖЛЫН ТАЙЛАН

НЭГ: Товч танилцуулга

Архангай аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дэргэдэх ёс зүйн дэд хороо нь анх байгууллагын үйл ажиллагаанд ёс зүй, шударга байдал, хариуцлагын зарчмыг хэрэгжүүлэх, сахин хамгаалах зорилготойгоор тус газрын нийт албан хаагчдын 2024 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн 05 дугаар хуралдаанаар 5 гишүүнтэй байхаар шийдвэрлэж, нэр дэвшүүлж, санал хураах зарчмаар сонгож, ёс зүйн дэд хорооны даргаар газрын татвар төлбөр, үнэлгээний асуудал хариуцсан мэргэжилтэн Н.Ариунзаяаг, нарийн бичгийн даргаар захиргаа, хуулийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн М.Тулга, гишүүдээр барилгын материалын үйлдвэрлэл, лабораторийн асуудал хариуцсан мэргэжилтэн А.Оюун-Эрдэнэ, газрын даамал Б.Батсайхан, барилга захиалагчийн хяналтын инженер Б.Заяа нарыг 5 жилийн хугацаатайгаар газрын даргын 2024 оны А/25 дугаартай тушаалаар томилж байгуулагдсан.

Тус ёс зүйн дэд хороо нь байгууллагын ажилтан, албан хаагчдын ёс зүйн хэм хэмжээ, зан төлөвийг төлөвшүүлэх, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, гарсан зөрчлийг холбогдох хууль, дүрэм, журамд нийцүүлэн хэлэлцэн дүгнэлт гаргах үндсэн чиг үүрэгтэйгээр жил бүр байгууллагын ёс зүйн зөвлөлийн тухайн ондоо хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж, ёс зүйн зөвлөлийн хийх ажлын хувиар батлан ажиллаж байна. 2025 онд хийх ажлын хувиар, төлөвлөгөөг 2025 оны 01 дүгээр хурлаараа хэлэлцэн баталсан байна.



БАЙГУУЛЛАГЫН ЁС ЗҮЙН ЗӨВЛӨЛИЙН 2025 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Арга хэмжээ	Шалгүүр үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хугацаа	Хариуцах эзэн
1	Ёс зүйн зөвлөлийн 2025 оны төлөвлөгөөг боловсруулан батлуулж, албан хаагчдад танилцуулах	Төлөвлөгөөний тоо	-	1	II-IV улирал	Ёс зүйн зөвлөл
2	"Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм"-ийг албан хаагчдад танилцуулах, сурталт зохион байгуулах	Сурталтад хамрагдсан албан хаагчдын тоо	-	30	II-IV улирал	Ёс зүйн зөвлөл
3	Төрийн албан хаагч ёс зүйн зөрчил гаргасан тухай гомдол, мэдээллийг шалгах, ёс зүйн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх	Гүйцэтгэлийн хувь	-	100	Тухай бүр	Ёс зүйн зөвлөл
4	"Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм"-ийн талаар асуулт хариултын уралдаант тэмцээн зохион байгуулах	Албан хаагчдын хамрагдалтын хувь	-	100	II-IV улирал	Ёс зүйн зөвлөл

ооо000ооо

ЁС ЗҮЙН ЗӨВЛӨЛИЙН 2025 ОНД ХИЙХ АЖЛЫН ХУВИАР

№	Үйл ажиллагаа	Хэнд	I улирал			II улирал			III улирал			IV улирал			Хариуцах
			1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	
1	Ажлын төлөвлөгөө боловсруулж батлуулах	албан хаагчдад													Н.Ариунзаяа
2	Түүний явцад зохион байгуулах сургалтын санаачлыг албан хаагчдаас авах	албан хаагчдад													А.Оюун-Эрдэнэ
3	Сургалтын төлөвлөгөө боловсруулж батлуулах	албан хаагчдад													М.Тулга
4	Төрийн албан хаагчийн бадруулах ёс зүйн дүрэм, журам танилцуулах ажлыг	албан хаагчдад													М.Тулга
5	Байгууллагын сайт, хүрээ хүний сайт, мэдээлэл хандлага, төлөвшилийн талаар сурвалж	албан хаагчдад													М.Тулга
6	Нөлөөллийн ажлыг зохион байгуулах	албан хаагчдад													Бүгд оролцох
7	Ёс зүй, хүнд сүрэлт зөвлөл, харилцаа хандлагын талаар зөвлөмж тэмцээн зохион байгуулах	албан хаагчдад													А.Оюун-Эрдэнэ Б.Заяа
8	Ёс зүйн зөвлөлийн бүтэц гарах, мэдээ мэдээлэл байршуулах	албан хаагчдад													Бүгд зохицох
9	Ирэх, хүлээн эгээдэс албан хаагчдын зөрчлөл хандлагын талаар санал зөвлөмжөө хийрдэг байршуулах	албан хаагчдад													Бүгд зохицох
10	Албан хаагчдын талаар ирүүлсэн гомдол санаалыг хүлээн авч дийдэргэх	албан хаагчдад													Бүгд оролцох

ХОЁР: Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар

2.1 Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт

Төрийн албан хаагчдын ёс зүйн мэдлэг, хариуцлагыг дээшлүүлэх, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, шударга, ил тод төрийн албыг төлөвшүүлэх зорилгоор Архангай аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дэргэдэх байгууллагын ёс зүйн дэд хороо нь 2025 оны үйл ажиллагааныхаа төлөвлөгөөндөө албан хаагчид аа ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлын хүрээнд дараах арга хэмжээнүүдийг тусган хэрэгжүүллээ.

Үүнд:

- Төрийн албан хаагчдад зориулсан ёс зүйн сургалт, мэдээллийн өдөр, танилцуулгыг зохион байгуулсан.
- Ёс зүйн дүрэм, холбогдох хууль тогтоомжийн талаарх мэдээлэл, зөвлөмжийг дотоод сүлжээ, самбараар тогтмол хүргэсэн
- Ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх агуулгатай санамж, зөвлөмж боловсруулж түгээсэн
- Ёс зүйн зөрчлийн талаарх гомдол, мэдээлэл хүлээн авах, шийдвэрлэх журмыг мөрдөн ажилласан
- Ёс зүйн дэд хорооны хуралдааныг зохион байгуулж, гарсан асуудлыг хэлэлцсэн
- Төрийн албан хаагчдад ёс зүйн талаарх зөвлөгөө, тайлбар өгсөн.
- Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр мэдээлэл хүргэсэн.

1. **Төрийн албан хаагчдад зориулсан ёс зүйн сургалт, мэдээллийн өдөр, танилцуулгыг зохион байгуулсан.**



2025 оны 02-р сард газрын даргын албан бичгээр сумдын даамал нартай гүйцэтгэлийн төлөвлөгөө байгуулах, мэргэжил арга зүйгээр хангах, ур чадвар, мэдээлэл өгөх зорилгоор зохион байгуулсан сургалтад аймгийн "Насан туршийн боловсролын газаз"-ын мэргэжилтэнээс **"Хувь хүний ёс зүй ба харилцаа хандлага"** сэдвээр байгууллагын нийт албан хаагчдад сургалт зохион байгуулсан.

2. ***Ёс зүйн дүрэм, холбогдох хууль тогтоомжийн талаарх мэдээлэл, зөвлөмжийг дотоод сүлжээ, самбараар тогтмол хүргэсэн.***



Байгууллагын ёс зүйн дэд хорооны 2025 оны үйл ажиллагааныхаа төлөвлөгөөндөө тусгагдсаны дагуу ёс зүйн дүрэм, шинээр батлагдсан хууль тогтоомжийг талаарх мэдээлэл, зөвлөмж, цаашид ямар чиглэлээр сургалт мэдээлэл авах сонирхолтой байгааг тогтмол санал хүсэлтээр авч ажиллаа.

3. *Ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх агуулгатай санамж, зөвлөмж боловсруулж түгээсэн.*



Архангай аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дэргэдэх байгууллагын ёс зүйн дэд хороо нь албан хаагч нартаа Ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх агуулагатай 1 багц санамж, зөвлөмж боловсруулж, 60 албан хаагчид түгээн танилцуулсан байна.

4. *Ёс зүйн зөрчлийн талаарх гомдол, мэдээлэл хүлээн авах, шийдвэрлэх журмыг мөрдөн ажилласан*

Газрын даамалд холбогдуулан иргэн Ж.Мөнхтуяагаас 2025 оны 11 дүгээр сарын 04-ны өдөр ирүүлсэн гомдлыг Ёс зүйн дэд хороо 2025 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэн Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.2-т заасан зөрчил тогтоогдоогүй тул 13 дугаар зүйлийн 13.3.1, 15 дугаар зүйлийн 15.1.4, 15.1.5 дахь заалтыг үндэслэн шомдлыг бүхэлд нь хангахгүй шийдсүгэй гэж дүгнэлт гарч газрын даргат уламжлан, гомдол гаргагч иргэн Ж.Мөнхтуяа, газрын даамал Ц.Отгондэлгэр нарт хүргүүлсэн байна.

5. *Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр мэдээлэл хүргэсэн.*

Тайлант хугацаанд ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр холбогдох хууль тогтоомж, журмыг сурталчлах, албан хаагчдад мэдээлэл, зөвлөгөө өгөх ажлыг зохион байгуулсан. Ашиг сонирхлын мэдүүлгийг үнэн зөв, цаг тухайд нь гаргах, хувийн ашиг сонирхол үүсэх нөхцөл байдалд албан үүрэг гүйцэтгэхээс татгалзах, удирдлага болон Ёс зүйн дэд хороонд тухай бүр мэдэгдэх талаар мэдээлэл хүргүүлэн ажилласан. Мөн ашиг сонирхлын зөрчил үүсэх эрсдэлтэй нөхцөл байдлыг тодорхойлох, бууруулах чиглэлээр санамж, зөвлөмж боловсруулж түгээснээр албан хаагчдын хууль, ёс зүйн талаарх мэдлэг, хариуцлага дээшилж, ашиг сонирхлын зөрчил гаргах эрсдэл буурсан.

2025 онд

- Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр хүргүүлсэн мэдээлэл, зөвлөмж: 10
- Мэдээлэл, сургалтад хамрагдсан албан хаагчдын тоо: 60
- Илэрсэн ашиг сонирхлын зөрчлийн эрсдэл: 1

2.2 Томилох эрх бүхий албан тушаалтны ёс зүйн манлайлал:

Байгууллагын албан тушаалд хүн томилж, шийдвэр гаргах эрх бүхий этгээд ёс зүй, ёс суртахуун, шударга байдал, хариуцлагын өндөр стандартуудыг баримтлахыг хэлнэ. Энэ нь зөвхөн албан тушаалын эрх мэдлийг ашиглах төдийгүй байгууллагын ёс зүйн соёлыг төлөвшүүлэх, бусдыг чиглүүлэх чадвартай байхыг шаарддаг.

Үүнд:

Томилох эрх бүхий албан тушаалтны ёс зүйн манлайллын 7 үндсэн зарчим

1. **Шударга байдал**

- Томилгоо болон шийдвэр гаргалт нь хувь хүний сонирхлоос ангид, үнэн бодит мэдээлэлд үндэслэгдсэн байна.

2. **Ил тод байдал**
   - Томилгооны шалгуур, үр дүн, шалтгааныг харилцан адил тэгш хүнд ойлгомжтой байдлаар мэдээлнэ.
3. **Хариуцлага**
   - Томилгоо, шийдвэрийн үр дагаврыг хүлээж, алдаа гарсан тохиолдолд хурдан засаж, тайлбарлах.
4. **Ёс зүйн манлайлал**
   - Өөрийн үйлдлээр бусдыг зөв, шударга ажиллахад уриалах.
   - Байгууллагын ёс зүйн соёлыг төлөвшүүлэхэд чиглэсэн шийдвэр гаргах.
5. **Хүний эрх, шударга өрсөлдөөн**
   - Аль ч хүн, бүлгийн эрхийг зөрчихгүй, адил тэгш боломж олгох.
   - Дискриминац болон ялгаварлан гадуурхалтаас ангид байх.
6. **Мэргэжлийн ур чадварыг дэмжих**
   - Томилсон хүний ур чадвар, хөгжлийг дэмжиж, байгууллагын урт хугацааны зорилттой нийцүүлэн сонголт хийх.
7. **Хувийн ашиг сонирхлоос ангид байх**
   - Хээл хахууль, урьдчилсан тохироо, гэр бүл, найз нөхдийн эрх ашигт үйлчлэхгүй байх. гэх мэт заримыг баримтлан ажилладаг.

Архангай аймгийн Газрын харилцаа барилга, хот байгуулалтын газрын даргын санаачлагаар 2025 онд байгууллагын нийт албан хаагчидын дунд 32 асуулга бүхий "Ёс зүйтэй", "Ур чадвартай", "Эелдэг хандлага"-тай төрийн албан хаагчийн google фром ашиглан санал асуулгаар тодруулсан.

Ёс зүйтэй төрийн албан хаагчаар – Ёс зүйн дэд хорооны нарийн бичгийн дарга М.Тулга, Ур чадвартай төрийн албан хаагч – Б.Сайнжаргал, Эелдэг хандлагатай төрийн албан хаагч-О.Мэндсайхан нар шалгарсан байна.

2.3. Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа:

Төрийн албан хаагчдын ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, ёс зүйн хэм хэмжээг хэвшүүлэх, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах замаар байгууллагын ёс зүйн соёлыг төлөвшүүлэх зорилгоор дараах арга хэмжээг зохион байгуулан ажилласан байна.

1. Ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх

Ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр санамж, зөвлөмж боловсруулж, байгууллагын нийт албан хаагчдад түгээж, ёс зүйн эрсдэлийг бууруулахад чиглэсэн ажлыг зохион байгуулсан.

2. Соён гэгээрүүлэх, сургалт

Ёс зүйн хууль тогтоомж, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр Архангай аймгийн "Насан туршийн боловсролын газаз"-тай хамтран **"Хувь хүний ёс зүй ба харилцаа хандлага"** сэдэвт сургалтыг 2025 оны 02 дугаар сард, Ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх агуулага бүхий тараах материал бэлтгэн албан хаагч нартаа мэдээлэл хүргүүлэн, сурталчилгааны ажлыг хэрэгжүүлж, албан хаагчдын мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэн ажилласан.

3. Хяналт, үнэлгээ

Байгууллагын хэмжээнд ёс зүйн хэм хэмжээний хэрэгжилтэд дүн шинжилгээ хийж, ёс зүйн эрсдэлийг тодорхойлон, бууруулах санал, зөвлөмжийг боловсруулж удирдлагад хүргүүлсэн.

4. Өргөдөл, гомдол, мэдээлэл шийдвэрлэлт

2025 онд Ёс зүйн дэд хороонд Эрдэнэбулган сумын иргэнээс 1 өргөдөл, гомдол ирсэнийг холбогдох хууль, журмын дагуу хүлээн авч, хянан шалгаж, дүгнэлт гарган ажилласан байна.

5. Дүгнэлт, санал хүргүүлэх

Хянан шалгасан асуудлын хүрээнд ёс зүйн зөрчилд дүгнэлт гаргаж, цаашид авах урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар байгууллагын удирдлагад хүргүүлсэн.

6. ДҮГНЭЛТ

Архангай аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Ёс зүйн дэд хороо нь 2025 онд ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, албан хаагчдын ёс зүйн хариуцлагыг дээшлүүлэхээр төлөвлөсөн ажил аа бүрэн хэрэгжүүлж ажилласны үр дүнд албан хаагчдын ёс зүйн талаарх мэдлэг, хариуцлага дээшилсэн, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх тогтолцоо сайжирсан, байгууллагын ёс зүйн соёл төлөвшсөн бодитой үр дүнд хүрсэн.

Гаргасан үр дүн, ололт амжилт:	Бэрхшээл:
- Албан хаагчдын ёс зүйн талаарх мэдлэг, хариуцлага дээшилсэн, - Ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх тогтолцоо сайжирсан, - Байгууллагын ёс зүйн соёл төлөвшсөн бодитой үр дүнд хүрсэн.	- Ёс зүйн (дэд) хорооны гишүүд үндсэн ажлынхаа хажуугаар үүрэг гүйцэтгэдэг тул ёс зүйн асуудалд зарцуулах цаг, боломж хязгаарлагдмал байна. - Албан хаагчдын ёс зүй, ашиг сонирхлын зөрчлийн талаарх мэдлэг, ойлголт харилцан адилгүй байгаа нь зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд хүндрэл учруулж байна. - Ёс зүйн сургалт, мэдээлэл, сурталчилгааны ажлыг тогтмол, тасралтгүй зохион байгуулахад санхүү, зохион байгуулалтын хүндрэл тулгарч байна.

	- Ёс зүйн зөрчил, эрсдэлийн талаарх мэдээллийг тухай бүр мэдэгдэх, ил тод мэдээлэх соёл бүрэн төлөвшөөгүй байна.

Санал:

1. Ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх санамж, зөвлөмж, мэдээллийг тогтмол хугацаанд боловсруулж, албан хаагчдад хүргэх, соён гэгээрүүлэх ажлыг жил бүрийн төлөвлөгөөнд тусгах.
2. Албан хаагчдын ёс зүй, ашиг сонирхлын зөрчлийн талаарх мэдлэг, ойлголтыг дээшлүүлэх зорилгоор сургалт, цахим болон танхимын хэлбэрийг хослуулан зохион байгуулах.
3. Ёс зүйн зөрчил, эрсдэлийн талаарх мэдээллийг нууцлалтай, аюулгүй байдлаар хүлээн авах сувгийг тодорхой болгож, албан хаагчдад зөвлөгөө өгөх механизмыг сайжруулах.
4. Ёс зүйн (дэд) хорооны гишүүдийн ажиллах нөхцөл, цагийн зохицуулалтыг сайжруулж, шаардлагатай сургалт, арга зүйн дэмжлэг үзүүлэх.

Шалгах хэсэг:

- ☑ "Ёс зүй, сахилга хариуцлагын үнэлгээний шалгуур үзүүлэлт"-ийн дагуу үнэлгээ хийсэн эсэх.
- ☑ Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтэд нийцүүлэн баталсан үйл ажиллагааны төлөвлөгөө хавсаргасан эсэх.
- ☑ Байгууллагын 2025 оны Ёс зүйн дэд хорооны хууль тогтоомжийн хэрэгжилтийн тайланг маягтын дагуу бүрэн тайлагнасан эсэх.

БАТАЛГААЖУУЛАЛТ:

Томилох эрх бүхий албан тушаалтан
Архангай аймгийн ГХБГБХГ-ын
дарга
/Албан тушаал/ */Гарын үсэг/* Ч.Отгонжаргал
/Гарын үсгийн тайлал/

Ёс зүйн дэд хорооны дарга
Газрын татвар, төлбөр
үнэлгээний асуудал хариуцсан
мэргэжилтэн
/Албан тушаал/ *Н. Ариунзаяа* */Гарын үсэг/* Н.Ариунзаяа
/Гарын үсгийн тайлал/

Ёс зүйн дэд хорооны нарийн бичгийн дарга
Захиргаа, хуулийн асуудал
хариуцсан ахлах мэргэжилтэн
/Албан тушаал/ */Гарын үсэг/* М.Тулга
/Гарын үсгийн тайлал/

Огноо: 2025 оны 12 дугаар сарын 30

БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН ГАЗРЫН
ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН
ГАЗАР
83120 Баян-Өлгий аймаг, Өлгий сум
Утас: 70422146, Факс: (976)70422146
Цахим шуудан: bayan-ulgii@gazar.gov.mn
Цахим хуудас: www.bayan-olgii.gazar.gov.mn

2026.01.05 № 1/4

танай -ны № -т

ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ЕРӨНХИЙ ГАЗАРТ

Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтйн тайланг хүргүүлэв.

Хавсралт 5 хуудас

Баян-Өлгий аймгийн газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар
Захиргаа
Дарга
Жабах Естай
2026-01-06 11:56:52

Ёс зүйн хорооны 2025 оны 12 дугаар
сарын 01-ний өдрийн 09 дүгээр тогтоолын
гуравдугаар хавсралт

БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН 2025 ОНЫ ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

Нэг. Товч танилцуулга

Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын даргын 2025.01.06-ны өдрийн А/01 дугаар тушаалаар ёс зүйн дэд хороо байгуулагдсан. Даргаар Х.Өмиржан, нарийн бичгээр Х.Айнур, гишүүнээр Х.Перизат нарыг томилон ажиллуулж байна. 2025 оны хийж гүйцэтгэх ажлын төлөвлөгөөг батлуулан хэрэгжилтийг ханган ажилласан.

ХОЁР. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар

2.1.Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх

1. Сургалт, сурталчилгааны ажил:

• Ёс зүйн сургалт:

- "Төрийн албан хаагчийн ёс зүйн тухайн" хууль, "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ" сэдвээр 1 удаагийн сургалт зохион байгуулж, 85 хувийг хамруулсан.
- Засаг даргын тамгын газраас зохион байгуулсан төрийн албан хаагчийн ёс зүйн сэдэвт сургалтад холбогдох албан хаагч нарыг хамруулсан.

• **Мэдээлэл түгээлт:** ТАЗ-өөс цаг үеийн холбогдолтой мэдээ мэдээллүүдийг байгууллагын дотоод сүлжээнд байршуулан нийт албан хаагчаар түгээлгэж, гарын авлагыг хэвлэн танилцуулсан байна.

2. Урьдчилан сэргийлэх арга хэмжээ:

• **Эрсдэлийн үнэлгээ:** Нийт албан хаагчдын 84,6 хувь эрсдэлийн үнэлгээнд хамрагдсан. Үнэлгээгээр байгууллагын үйл ажиллагаа, зохион байгуулалт, соёлын тухайд тохиолдож буй бэрхшээлийг тодорхойлох үнэлгээгээр эрсдэл өндөр тогтоогдож эрсдэлтэй 12 албан хаагчдыг тогтоож нөлөөллийн мэдүүлэг хөтлүүлэн баталгаажууллаа. Дээрхи албан хаагчдын ажлын ачааллыг тэнцвэржүүлэх талаар холбогдох нэгжийн дарга нартай шийдвэрлэх асуудлыг хэлэлцэн авах арга хэмжээг шийдвэрлэлээ.

• **Зөвлөн туслах үйлчилгээ:** 2025 оны 4 дүгээр сарын 21-ний өдөр ёс зүйн дэд хорооноос гарч болзошгүй эрсдлийн зөвлөмжийг нийт алба хаагчдад танилцуулан эрсдэлд өртөж болзошгүй иргэдтэй шууд харьцдаг 12 алба хаагчдад зөвлөмж хүргүүлэн ажилласан байна.

3. Соён гэгээрүүлэх үйл ажиллагаа:

• **Соёлын нөлөөлөл:** "Эерэг харилцаа, эерэг хандлага" аяныг өрнүүлж 2 албан хаагчийг шалгаруулан урамшуулсан.

4. Хяналт-шинжилгээ, үнэлгээ:

• Сургалт болон нөлөөллийн мэдүүлэг хөтлүүлэн баталгаажуулсан болон нийт албан хаагчдын дунд хандлага эерэг болж нөлөөлсөн гэж дүгнэж байгаа.
• 2025 онд иргэдээс ирүүлсэн 1 гомдлыг хүлээн авч шийдвэрлэж дүгнэлт гаргасан. Гомдол нь газрын даамалд холбоотой харилцаа хандлагад гаргасан гомдол байна.

2.2.Томилох эрх бүхий албан тушаалтны ёс зүйн манлайлал:

• **Ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх:** Байгууллагын бүх албан хаагчдыг Авлигын эсрэг хуулийн 7.1.3, 1.2, Төрийн албаны тухай хуулийн 13.1.1, Монгол улсын үндсэн хуулийн 13.1.3, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль... гэх мэт холбогдох хууль тогтоомжийн зүйл заалтуудыг уншиж судалсан заавар чиглэл өгч ажиллав.

1. **Бодлогын болон шийдвэрийн манлайлал:**

• **Тушаал, шийдвэр:** Байгууллагын албан хаагчдаас санал авч саналын дагуу Газрын даргын 2025 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн А/01 тоот тушаалаар ёс зүйн дэд хороог байгуулсан.
• **Нээлттэй байдал:** Байгууллагын шагнал авах шалгуур хангасан албан хаагч нарыг даргын зөвлөлийн хурлаар нэр дэвшүүлэн, санал хураах зарчмаар тодорхойлон холбогдох бичиг баримтыг бүрдүүлж, дээд шатны байгууллагад хүргүүлэн ажилладаг.

2. **Ёс зүйн зөрчилд хандах хандлага:**

• **Шударга байх:** Зөрчил, дутагдал гаргасан албан хаагчдыг Ёс зүйн дэд хороонд хүргүүлж ажилласан.

3. **Харилцаа, соёлын манлайлал:**

• **Сэтгэл зүйн аюулгүй байдал:** Засаг даргын тамгын газраас зохион байгуулсан жендерийн сургалтад холбогдох албан хаагчдыг хамруулсан.
• **Санал гомдлыг сонсох:** Албан хаагчдын санал, хүсэлтийг тухаи бүр биечлэн уулзаж, шуурхай шийдвэрлэн ажилладаг.

2.3. Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа:

1. **Зохион байгуулалтын арга хэмжээ:**

• **Бүрэлдэхүүн:** Дэд хорооны бүрэлдэхүүнийг шинэчилсэн эсэх, гишүүдийн ажиллах нөхцөл, нөөц боломжийг бүрдүүлсэн байдал.
• **Төлөвлөлт:** Ажлын төлөвлөгөөг баталж, гүйцэтгэлийг хийж хэрэгжүүлэх гишүүн бүрээр хянан дүгнэсэн.
• **Хурлын ирц:** Тайлант хугацаанд нийт 3 удаа хуралдаж, гомдолд дүгнэлт гаргасан байна. Хуралдаанд 100 хувь бүрэн хамрагдан ажилласан.

2. **Гомдол, мэдээллийн шийдвэрлэлт:**

• **Хүлээн авсан гомдол:** 2025 оны байдлаар ГХБХБГ-ын ёс зүйн дэд хороо ирүүлсэн 1 гомдлыг хүлээн авч шийдвэрлэсэн байна.
• **Шийдвэрлэлтийн явц:** Ирүүлсэн 1 гомдолд Ёс зүйн дэд хорооны дүгнэлт гаргасан.
• **Сахилгын шийтгэлийн санал:** Зөрчил гаргасан 1 гомдол сахилгын шинжтэй тул Газрын даргын тушаалаар сахилгын шийтгэл ногдуулсан болно.

3. **Зөвлөн туслах, соён гэгээрүүлэх ажил:**

• **Зөвлөмж:** 2025 оны 04 дүгээр сарын 21-ний өдөр ёс зүйн дэд хорооноос гарч болзошгүй эрсдлийн зөвлөмжийг нийт алба хаагчдын эрсдэлд өртөж болзошгүй иргэдтэй шууд харьцдаг 12 алба хаагчдад зөвлөмж хүргүүлэн ажилласан байна.

3. Тайлагнал ба нээлттэй байдал:

• **Тайлагнал:** Ёс зүйн хорооны тайлан мэдээг тухай бүр мэйл хаягнаас хүргүүлэн тайлагнасан байна.

• **Судалгаа:** Байгууллагын ёс зүйн төлөв байдал, соёлын талаар албан хаагчдын дунд судалгаа авч, дүгнэлт гаргасан эсэх.

Гарсан үр дүн, ололт амжилт:	Бэрхшээл:
• Эрсдэл өндөртэй албан хаагчид эрсдэлд өртөж болох нөхцөл байдлыг сануулан нөлөөлөлийн мэдүүлэг хөтлүүлэн баталгаажуулснаар тухайн албан хаагч өөртөө дүгнэлт хийн харилцаа хандлага дээрээ анхаарч ажиллаж байгаа ажиглагдсан.	• Ёс зүйн зөвлөлийн гишүүд үндсэн ажлынхаа зэрэгцээ энэ үүргийг гүйцэтгэдэг тул цаг хугацааны хувьд ачаалал ихтэй байх. • Соён гэгээрүүлэх болон нөлөөллийн ажил зохион байгуулахад шаардлагатай төсөв хөрөнгөгүй. • Зарим албан хаагчдын дунд ёс зүйн хэм хэмжээг "хувийн асуудал" гэж үзэх, шүүмжлэлийг хүлээн авах чадвар дутмаг байдаг.

Санал:

1. Төсөв суулгах:

• Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд албан хаагчдын ажлын ачааллаас үүдэлтэй стресс, "burnout" буюу ажлаас халшрах хам шинжийг оношлох, мэргэжлийн сэтгэл зүйчийн ганцаарчилсан болон багийн зөвлөгөө авах зардлыг,

• Нийт гомдлын дийлэнхи хэсэг харилцаа, хандлагатай холбоотой байх тул мөн тухайн асуудалтай холбоотой байгаа тул сургалт авах зардлыг байгууллагын жил бүрийн төсөвт тусгайлан тусгаж батлах.

2. Урьдчилан сэргийлэх тогтолцоо:

• Ёс зүйн зөрчлийн шалтгаан нөхцөлд хийсэн дүн шинжилгээгээр хувь хүний хандлагаас гадна ажлын орчны таагүй нөлөөлөл, сэтгэл зүйн тогтворгүй байдал ихээхэн нөлөөлж байгаа тул байгууллагын дэргэд "Сэтгэл зүйн зөвлөгөө өгөх өрөө" эсвэл гэрээт сэтгэл зүйч ажиллуулах эрх зүйн зохицуулалтыг бий болгох.

3. Дээд шатны байгууллагад:

• Төрийн албаны зөвлөл болон Ёс зүйн хорооноос төрийн байгууллагуудад зориулсан "Сэтгэл зүйчийг ажиллуулах жишиг журам", "Сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх төсвийн норматив"-ыг батлаж өгөхөд дэмжлэг үзүүлэх.

Шалгах хэсэг:

✓ "Ёс зүй, сахилга хариуцлагын үнэлгээний шалгуур үзүүлэлт"-ийн дагуу үнэлгээ

хийсэн эсэх.

✓ Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтэд нийцүүлэн баталсан үйл ажиллагааны төлөвлөгөө хавсаргасан эсэх.

✓ Байгууллагын 2025 оны Ёс зүйн дэд хорооны хууль тогтоомжийн хэрэгжилтийн тайланг маягтын дагуу бүрэн тайлагнасан эсэх.

БАТАЛГААЖУУЛАЛТ:

Томилох эрх бүхий албан тушаалтан Ж.Естай

Ес зүйн дэд хорооны дарга Х.Өмиржан

Ёс зүйн дэд хорооны нарийн бичгийн дарга Х.Айнур

Огноо: 2025 оны 12 сарын 30

БАЯНХОНГОР АЙМГИЙН ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗАР
306 дугаар байр, Чандмань гудамж 3, Номгон 1 дүгээр баг, Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101
Утас: (976) 70442114, 70442088, Факс: 70442088
Цахим шуудан: ghbhbgazar@gmail.com
Цахим хуудас: bayankhongor.gazar.gov.mn

2025.12.30 № 866

танай 2025.12.23 -ны № 2/4046 -т

ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГА А.ЭНХМАНЛАЙ ТАНАА

Төрийн албан хаагчийн ёсзүйн тухай хууль, тогтоомжийн хэрэгжилтийн тайланг батлагдсан маягтын дагуу гарган хүргүүлж байна.

Хавсралт 5 хуудастай.

Баянхонгор аймгийн газрын харилцаа барилга хот байгуулалтын газар
Захиргаа удирдлагын хэлтэс
Газрын дарга
Дард Алтангэрэл
2025-12-30 17:12:52

БАЙГУУЛЛАГЫН 2025 ОНЫ ЁСЗҮЙН ДЭД ХОРООНЫ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

2025 оны 12 дугаар сарын 30 Номгон

НЭГ. Товч танилцуулга
Ёс зүйн дэд хорооны 2025 оны төлөвлөгөөг 7 арга хэмжээтэй боловсруулан хэрэгжилтийг хангаж ажилласан. Ёс зүйн дэд хороо нь удирдамжтай 1 арга хэмжээ, аянд нэгдэж төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийг хугацаанд нь холбогдох газруудад хүргүүлсэн. Ёс зүйн хорооноос зохион байгуулсан "Хүндлэе-Энэрье" нөлөөллийн аянд төлөвлөгөөний аянд нэгдэж албан хаагчдыг соён гэгээрүүлэх үйл ажиллагааг зохион байгуулж ажилласан.
ХОЁР. Төрийн албан хаагчийн ёсзүйн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар
2.1. Төрийн албан хаагчийн ёсзүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт
"Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр"-ын хэрэгжилтийг "Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт"-ийн дагуу гаргаж аймгийн Засаг даргын тамгын газарт хүргүүлсэн. Шалгуур үзүүлэлтэд тусгасан төрийн байгууллага хариуцан, хамтран хэрэгжүүлэх шаардлагатай Үндэсний 2, Салбарын 3, Хөтөлбөрийн 11, нийт 16 арга хэмжээний хүрээнд хэрэгжүүлж ажилласан.
2.2. Томилох эрх бүхий албан тушаалтны ёсзүйн манлайлал:
Байгууллагын албан хаагчдыг сургах нөхцөл бололцоогоор бүрэн хангаж ажилладаг. Тухайлбал Өвөрхангай аймагт зохион байгуулагдсан "Бүсчилсэн хөгжил-Төрийн албаны манлайлал" хангайн бүсийн зөвлөгөөнд байгууллагын төлөөлөлийг хамрагдах нөхцөл бололцоогоор хангасан. Тус байгууллагын батлагдсан төсөвт Ёс зүйн дэд хорооны гишүүдэд урамшуулал олгох, нэмэлт санхүүжилтээр дэмжих зардал тусгагдаагүй бөгөөд төсвийн боломж хязгаарлагдмал байгаа тул олгоогүй болно.
2.3. Ёсзүйн дэд хорооны үйл ажиллагаа
Байгууллагын ёс зүйн дэд хороо нь 2024.05.27-ны өдрийн А/15 дугаар тушаалаар шинэчлэн байгуулагдсан. Дэд хорооны даргаар Газар зохион байгуулалт, төлөвлөлт, газар өмчлөлийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн С.Должинсүрэн, Нарийн бичгийн даргаар Ерөнхий нягтлан бодогч Э.Амарбаясгалан, гишүүндээр Барилгын материалын үйлдвэрлэлийн Лабораторийн асуудал хариуцсан хариуцсан мэргэжилтэн Ж.Сүглэгмаа, Баянхонгор сумын Газрын даамал Х.Баасанжаргал, Богд сумын Газрын даамал Ж.Үүрцайх нар ажиллаж байна. Тайлант хугацаанд Ёс зүйн дэд хороо нь 2025 оны хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө болон, "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр"-ийн зорилго, зорилттой уялдуулан үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлж ажилласан. Хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу ёс зүйн сургалт, нөлөөллийн ажил, аян, соён гэгээрүүлэх арга хэмжээг зохион байгуулж, албан хаагчдын ёс зүйн мэдлэг, хандлага, хариуцлагыг дээшлүүлэх чиглэлээр үйл ажиллагааг зохион байгуулсан.

Гарсан үр дүн, ололт амжилт:	**Бэрхшээл:**
Ёс зүйн дэд хороо нь ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх,	

чиглэлээр төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлж ажилласан. Албан хаагчдын ёс зүйн мэдлэг, харилцаа хандлага, сахилга хариуцлага сайжирсан. “Ёс зүйгээр манлайлагч байгууллага”, “Хүндэлье–Энэрье” аяны хүрээнд байгууллагын албан хаагчдад нөлөөллийн арга хэмжээг хүргэсэн. Албан тушаалтнууд сургалт, зөвлөгөөнд идэвхтэй хамрагдсан Байгууллагын цахим хаягуудаар иргэдэд тогтмол мэдээлэл хүргэсэн. Байгууллага дээр албан хаагчдын Ёсзүйн харилцаа хандлагатай холбоотой цахим санал авах нөхцөлийг бүрдүүлсэн. Төрийн албан хаагчийн Ёс зүйн дүрмийг гарын авлага байдлаар албан хаагч бүрт хүргэж танилцуулсан.	Ажлын ачаалал, Тайлан, жилийн эцсийн ажлууд давхцсанаас зарим аян арга хэмжээнд оролцох боломжгүй болсон. Албан хаагчдын сэтгэлзүйн дэмжлэг, стресс бууруулах чиглэлийн мэргэжлийн сургалт хийгдээгүй.
Санал: Сургалт зохион байгуулах: Жилд дор хаяж 2 удаа мэдлэг бататгах сургалт, хэлэлцүүлэг зохион байгуулах. Ёс зүйн нөлөөллийн контентыг тогтмол түгээх, Видео, постер, бодит кейс, сайн туршлагыг олон нийтийн сүлжээгээр түгээх. Урамшууллын асуудлыг шийдвэрлэх: Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа жигд явагдаж байгаа хэдий ч ажлын ачааллаас шалтгаалан хүндрэл үүсдэг. Энэхүү байдлыг урамшуулах, үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэхэд ёс зүйн дэд хорооны гишүүдийн урамшуулал чухал нөлөөтэй. Гэвч Төсвийн хэмнэлттэй холбоотой урамшууллын зардлыг хассан.	

Шалгах хэсэг:

- “Ёс зүй, сахилга хариуцлагын үнэлгээний шалгуур үзүүлэлт”-ийн дагуу үнэлгээ хийсэн эсэх
- Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтэд нийцүүлэн баталсан үйл ажиллагааны төлөвлөгөө хавсаргасан эсэх.
- Байгууллагын 2025 оны Ёс зүйн дэд хорооны хууль тогтоомжийн хэрэгжилтийн тайланг маягтын дагуу бүрэн тайлагнасан эсэх

БАТАЛГААЖУУЛАЛТ:
ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН
ДАРГА Д.АЛТАНГЭРЭЛ

ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ ДАРГА
ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ТӨЛӨВЛӨЛТ
ГАЗАР ӨМЧЛӨЛИЙН АСУУДАЛ ХАРИУЦСАН АХЛАХ
МЭРГЭЖИЛТЭН С.ДОЛЖИНСҮРЭН

ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ НАРИЙН БИЧГИЙН ДАРГА
(ЕРӨНХИЙ НЯГТЛАН БОДОГЧ) Ж.БИЛГҮҮНТӨГӨЛДӨР

Огноо:2025 оны 12 сарын 30

БУЛГАН АЙМГИЙН
ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА,
ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗАР
Чин Ван Ханддоржийн өргөн чөлөө 1-115,
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082
Утас: 7034-2348, Факс: 7034-2409
Цахим шуудан: bulganghbhbg@gmail.com
Цахим хаяг: www. bulgan.gazar.gov.mn

2025.12.30 № 01/1206

танай 2025.12.23 -ны № 2/4046 -т

ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ,
ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ЕРӨНХИЙ ГАЗАРТ

Байгууллагын ёс зүйн дэд хорооны 2025 оны “Ёс зүй, сахилга хариуцлагын үнэлгээний шалгуур үзүүлэлт, маягт”-ын дагуу хэрэгжилтийн тайланг гаргаж хавсралтаар хүргүүлэв.

Хавсралт 02 хуудас.

БУЛГАН АЙМГИЙН ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН 2025 ОНЫ ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

НЭГ: Товч танилцууллага
Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-т заасны дагуу тайланд хугацаанд тус байгууллагын албан хаагчдтай холбоотой гомдол, мэдээлэл ёс зүйн дэд хороонд гаргаагүй болно. Мөн тайланд хугацаан албан хаагчдын соён гэгээрүүлэхтэй холбоотойгоор албан хаагчдад болон газрын даамлуудын нэгдсэн 2 удаагийн сургалтаар Төрийн албан тухай болон Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Авлигын тухай хууль тогтоомжуудаар мэдээлэл өгөх, мөн Харилцааны ухааны доктор Н.Алтанцоож-оор харилцааны ур чадварын чиглэлээр сургалтыг нийт албан хаагчдад өгч ажиллаа.
ХОЁР: Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар
2.1. Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт: Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр/2024-2030 он/
Төрийн албан хаагчийн харилцаа, хандлагыг сайжруулах чиглэлээр Харилцааны ухааны доктор Н.Алтанцоож-оор харилцааны ур чадвар, ёс зүйн чиглэлээр 2.5 цагийн сургалтыг нийтийн албан хаагчдын нэгдсэн сургалтын үеэр мэдээлэл, хичээлд хамруулсан. Мөн нийт төрийн захиргааны албан хаагчдаас авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид, авлигын гэмт хэрэгт холбогдохгүй байх, албандаа шударга ажиллах тухай 4 заалт бүхий баталгааг гаргуулан авч нэг хувийн нь төрийн албан хаагчийн хувийн хэрэгт хавсарган ажилласан.
2.2. Томилох эрх бүхий албан тушаалтаны ёс зүйн манлайлал:
Байгууллагын албан хаагчдыг томилох эрх бүхий албан тушаалтан буюу газрын дарга нь улс, бүсийн хэмжээнд зохион байгуулагдсан сургалт, семинарын мэдээлэл, аймагт зохион байгуулагддаг удирдах ажилтны болон шуурхай хуралдаанаас гарсан мэдээллийг нийт албан хаагчдад танилцуулна. Мөн долоо хоног бүрийн ажлын хоёр дахь өдөр нийт албан хаагчдын хуралдааныг тогтмол зохион байгуулж, үүрэг даалгавар, чиглэл өгч, өмнөх долоо хоногт өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилттэй танилцана. Түүнчлэн сургалтад хамрагдсан албан хаагчид тухайн хуралдаанд мэдээлэл өгдөг байх ажлыг тогтмолжуулан хэрэгжүүлж ажилладаг.
2.3. Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа:
Ёс зүйн дэд хороо нь албан хаагчдыг хууль тогтоомж, төрийн албан хаагчийн ёс зүйн хууль, дүрэм, журмыг мөрдөхөд чиглэсэн соён гэгээрүүлэх ажлыг тогтмол зохион байгуулж ажилласан. Тайлант хугацаанд ёс зүйн чиглэлээр **2 удаагийн сургалт, мэдээлэл** зохион байгуулж, нийт **21 албан хаагч** хамрагдсан байна. Мөн албан хаагчдын ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор **4 удаагийн зөвлөмж, мэдээлэл** хүргүүлж, иргэдэд төрийн үйлчилгээг чирэгдэлгүй, түргэн шуурхай үзүүлэх талаар дотоод хяналт, санамжийг тогтмол өгсөн. Үүний үр дүнд тайлант хугацаанд ёс зүйн зөрчил, гомдол мэдээлэл илэрээгүй зөрчилгүй ажиллалаа.

Гарсан үр дүн, ололт амжилт:	**Бэрхшээл**
Тус байгууллагын нийт албан хаагчдын хууль эрх зүйн мэдлэг сайжирж, албандаа шударгаар ажиллах байгаа бөгөөд үний нэг жишээ нь байгууллагын ёс зүйн дэд хороонд албан хаагчтай	Байгууллагын төсөвт байгуулагын ёс зүйн дэд хорооны урамшуулалыг тусгаж өгөх.

холбоотой гомдол мэдээлэл ирээгүй болно.	
Санал:	
Байгуулагын төсөвт ёс зүйн дэд хорооны урамшуулал төсөв тусгах, мөн албан хаагчдийн сургах, мэргэжлийн лектор хичээл авах, гарын авлага тохимол бэлтгэхэд шаардлагатай төсийг байгууллагын төсөвт тусад ангилалаар оруулах	

Шалгах хэсэг:

- “Ёс зүй, сахилга хариуцлагын үнэлгээний шалгуур үзүүлэлт”-ийн дагуу үнэлгээ хийсэн эсэх
- Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтэд нийцүүлэн баталсан үйл ажиллгаааны төлөвлөгөө хавсаргасан эсэх
- Байгууллагын 2025 оны Ёс зүйн дэд хорооны хууль тогтоомжийн хэрэгжилтийн тайланг маягтын дагуу бүрэн тайлагнасан эсэх

БАТАЛГААЖУУЛАЛТ:

Томилох эрх бүхий албан тушаалтан:
Газрын харилцаа, барилга, хот
Байгуулалтын газрын дарга Ү.Бямбасүрэн

Ёс зүйн дэд хорооны дарга
Газрын удирдлагы хэлтсийн дарга С.Наранбаатар

Ёс зүйн дэд хорооны нарийн бичгийн дарга
Газар өмчлөл, газар зохион байгуулалт
Төлөвлөлтийн асудал хариуцсан ахлах мэргэжилтэн С.Юмжав

2025 оны 12 дугаар сарын 30-ны өдөр

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ
ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА
ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗАР

Оргил баг, Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82099
Цахим шуудан:govialtai@cfga.gov.mn
Утас: 7048-3098, Факс: 7048-3048

2026. 01. 13 № 20

танай _____ -ны № _____ -т

ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ЕРӨНХИЙ ГАЗАРТ

Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн тайланг батлагдсан шалгуур үзүүлэлт, маягтын дагуу бэлтгэн хүргүүлж байна.

Хавсралт.3. хуудастай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Ж.МЯНГАНБАЯР

82260300

D:/GHBHBG/A-5toot.doc

Ёс зүйн хорооны 2025 оны 12 дугаар
сарын 01ний өдрийн 09 дугаар тогтоолын
гуравдугаар хавсралт

БАЙГУУЛЛАГЫН 2025 ОНЫ ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАНГИЙН МАЯГТ

НЭГ. Товч танилцуулга
Говь-Алтай аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын Ёс зүйн дэд хороо нь газрын даргын 2025 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн А\05 дугаар тушаалаар байгуулагдаж Ёс зүйн дэд хорооны даргаар Газрын удирдлагын хэлтсийн дарга А.Пүрэвсэд, гишүүдээр Д.Мөнхтуяа, Г.Бат-Эрдэнэ, М.Мөнхцэцэг нар, нарийн бичгийн даргаар М.Саранзаяа нарын бүрэлдэхүүнтэй батлагдсан.
ХОЁР. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар
2.1 Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт
Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрт тусгагдсан зорилт арга хэмжээний хүрээнд төрийн албан хаагч ёс зүй, харилцаа, хандлагаараа олон нийтэд үлгэрлэх соёлыг төлөвшүүлэхэд чиглэсэн сургалт, нөлөөллийн арга хэмжээ, төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомжийг мөрдүүлэн хэрэгжилтийг ханган ажиллаж байна.
2.2 Томилох эрх бүхий албан тушаалтны ёс манлайлал:
Байгууллагын албан хаагчдын ажиллах таатай нөхцөл, ёс зүйн орчныг бүрдүүлэх, ёс зүйтэй албан хаагчийн нөөцийг бүрдүүлэх, хөгжүүлэх зорилгоор 2 удаа нөлөөллийн ажил зохион байгуулж нийт албан хаагчдыг хамруулан ажилласан. Мөн албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган ажиллаж байна.
2.3 Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа
Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрт тусгагдсан зорилт арга хэмжээний хүрээнд төрийн албан хаагч ёс зүй, харилцаа, хандлагаараа олон нийтэд үлгэрлэх соёлыг төлөвшүүлэхэд чиглэсэн сургалт, нөлөөллийн арга хэмжээ, төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомжийг мөрдүүлж, ёс зүйтэй, шударга ажиллах талаар ойлголт, хандлага, өөрчлөлт бий болгох зорилгоор танхимын 2 сургалт, цахим 4 сургалт зохион байгуулсан.

Гарсан үр дүн, ололт ,амжилт	Бэрхшээл
Тайлант хугацаанд ёс зүйн зөрчил илрээгүй, албан хаагчдын ёс зүйн мэдлэг дээшилсэн.	-

Санал
-

Шалгах хэсэг

☐ Ёс зүй, сахилга хариуцлагын үнэлгээний шалгуур үзүүлэлт ийн дагуу үнэлгээ хийсэн эсэх.

☐ Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнгийн хяналт шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтэд нийцүүлэн баталсан үйл ажиллагааны төлөвлөгөө хавсаргасан эсэх

☐ Байгууллагын 2025 оны Ёс зүйн дэд хорооны хууль тогтоомжийн хэрэгжилтийн тайланг маягтын дагуу бүрэн тайлагнасан эсэх.

БАТАЛГААЖУУЛАЛТ:

ТОМИЛОХ ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТАН

ГАЗРЫН ДАРГА \.....\ \Ж.МЯНГАНБАЯР\
\Албан тушаал *\Гарын үсэг* *\Гарын үсгийн тайлал*

ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ ДАРГА

ГАЗРЫН УДИРДЛАГЫН
ХЭЛТСИЙН ДАРГА \.....\ \А.ПҮРЭВСЭД\
\Албан тушаал *\Гарын үсэг* *\Гарын үсгийн тайлал*

ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

ЗАХИРГАА, ХУУЛИЙН АСУУДАЛ
ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН \.....М.Саранзаяа.....\ \М.САРАНЗАЯА\
\Албан тушаал *\Гарын үсэг* *\Гарын үсгийн тайлал*

Огноо:.....оны...сарын....

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН
ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА,
ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗАР

Найрамдал хотхон, 3 дугаар баг,
Сүмбэр сум, Говьсүмбэр аймаг, 42015
Утас: 7054 3387, Цахим шуудан: govisumber@gazar.gov.mn,
Цахим хуудас: www.govisumber.gazar.gov.mn

2025.12.30 № 01/1564

танай _____-ны № _____-т

ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ,
ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ЕРӨНХИЙ
ГАЗРЫН ДАРГА А.ЭНХМАНЛАЙ ТАНАА

Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн тайланг батлагдсан маягтын дагуу гарган хүргүүлэв.

Хавсралт 2 хуудастай.

ДАРГА Б.ОТГОНЧИМЭГ

Ёс зүйн хорооны 2025 оны 12 дугаар
сарын 01-ний өдрийн 09 дугаар тогтоолын
гуравдугаар хавсралт

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН 2025 ОНЫ ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

НЭГ. Товч танилцуулга
Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын даргын 2023 оны А/12 дугаар тушаалаар байгууллагын "Ёс зүйн дэд хороо"-г байгуулсан. Тус дэд хорооны даргаар Газрын удирдлагын хэлтсийн дарга Э.Баярмагнай, гишүүдээр Барилга, хот байгуулалтын газрын дарга Б.Даваажаргал, Газар, геодези зураг зүйн улсын байцаагч Д.Ганзориг нар томилогдон ажиллаж байна. Байгууллагын ёс зүй дэд хорооны 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд 13 арга хэмжээ зохион байгуулахаар төлөвлөж, 2025 оны 02 дугаар сарын 18-ний өдөр албан хаагчдад танилцуулан Газрын даргаар батлуулан ажилласан. 2025 оны байдлаар ёс зүйн дэд хороонд албан хаагчдын ёс зүй, үйл ажиллагаатай холбоотой гомдол мэдээлэл ирээгүй байна.
ХОЁР. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар
2.1 Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт
Байгууллагын ёс зүй дэд хорооны 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд батлагдсаны дагуу дараах сургалт, албан хаагчдыг соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулсан. Төрийн албан хаагчийг ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх Авлига, ашиг сонирхолын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, албан хаагчдын мэдлэг ойлголтыг сайжруулах зорилгоор аймгийн Прокурорын газарт хүсэлт тавьсны дагуу Ерөнхий прокурор, хууль цаазын итгэмжит зөвлөх Т.Нансалмаа 2025 оны 09 дүгээр сарын 25-ны өдөр байгууллагын албан хаагчдад сургалт зохион байгууллаа. Сургалтад байгууллагын 12 албан хаагч хамрагдсан бөгөөд цаашид анхаарах асуудлууд болон холбогдох зөвлөгөө, зөвлөмж өгөхийн зэрэгцээ албан хаагчид асууж тодруулах зүйлсээ асууж харилцан ярилцсан маш үр дүнтэй сургалт зохион байгууллаа. Мөн "Ёс зүйтэй төрийн жинхэнэ албан хаагч" сэдвээр Барилга, хот байгуулалтын хэлтсийн дарга Б.Даваажаргал байгууллагын нийт албан хаагчдад 2025 оны 09 дүгээр сарын 24-ний өдөр сонирхолтой сургалт зохион байгуулсан.
2.2 Томиолох эрх бүхий албан тушаалтны ёс зүйн манлайлал
Байгууллагын ёс зүй дэд хорооны 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг 2025 оны 02 дугаар сарын 19-ний өдөр байгууллагын цахим хуудсанд байршуулж, мөн тухайн зохион байгуулсан ажлын тайланг байгууллагын пэйж хуудас болох "Говьсүмбэр аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар"-т байршуулан ажилласан байна. Байгууллагад 2025 онд шинээр ажилд томилогдсон мэргэжилтэн Т.Энхжин, шилжин ажиллахаар томилогдсон Баянтал сумын газрын даамал Б.Батчимэг, жирэмсний амралттай байсан Кадастрын мэргэжилтэн Б.Алтантуяа нартай ёс зүйн дэд хорооны гишүүд уулзалт ярилцлага зохион байгуулж, төрийн албан хаагчийн ёс зүйн дүрэм, байгууллагын дотоод журам зэргийг танилцуулж ёс зүйтэй ажиллахыг танилцуулж ажилласан байна. Байгууллагын "Ёс зүйн дэд хороо"-ны 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу 10 шалгуур үзүүлэлтээр "Байгууллагын ёс зүйтэй албан хаагч"-ийг хамт олны үнэлгээгээр шалгаруулаа. 2025 оны "Байгууллагын ёс зүйтэй албан хаагч"-аар байгууллагын дарга Б.Отгончимэг хамт олны үнэлгээгээр "Тэргүүн байр" эзэлж, дурсгалын зүйл гардууллаа. Албан хаагчдад цаашид анхаарах асуудлуудыг танилцуулж ажилласан.
2.3 Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа
Байгууллагын ёс зүй дэд хорооны 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд 13 арга хэмжээ зохион байгуулахаар төлөвлөж, 2025 оны жилийн эцсийн байдлаар 100 хувь бүх арга хэмжээг зохион байгуулан ажилласан байна. Мөн аймгийн төрийн байгууллагуудын ёс зүйн дэд хороодын дунд хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, мэтгэлцэх, багаар хамтран ажиллах ур чадварыг дээшлүүлэх зорилготой мэтгэлцээний тэмцээнд Гутгаар байранд шалгарсан амжилт гаргасан. Мөн байгууллагын албан хаагчдыг сургалт хөтлөбөрөөс гадна албан хаагчдынхамтын ажиллагааг сайжруулах зорилгоор бусад арга хэмжээг зохион байгуулсан. үүнд: "Байгууллагын ёс зүйн дэд хороо"- ны 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу албан хаагчдын дунд "Өглөөний цай" арга хэмжээг зохион байгууллаа. Тус арга хэмжээгээр албан хаагчдын баг хамтын ажиллагааг сайжруулах, нөхөрсөг уур амьсгалыг нэмэгдүүлэх, харилцан бие биенийхээ сайн сайхан чанарыг илэрхийлэх байдлаар идэвхижүүлэх, шинээр томилогдсон албан

хаагчдыг хамт олонд нээлттэй байлгах зорилгоор зохион байгуулсан нь үр дүн сайтай, сайшаалтай байлаа. “Байгууллагын ёс зүйн дэд хорооны” 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу албан хаагчдын гэр бүлийн дунд гар бөмбөгийн нөхөрсөг тэмцээн зохион байгуулж, гэр бүлээрээ цагийг зөв боловсон өнгөрөөх, хамт олон, гэр бүл харилцан бие биеэ илүү таньж мэдэх боломжийг олгосон ач холбогдол сайтай тэмцээн болж өдөрлөлөө. Тус тэмцээнд Б.Дэлгэрдалай ахлагчтай баг тамирчид тэргүүн байр эзэлсэн. Улирал бүр Нэгжийн дарга нар албан хаагчидтай уулзалт ярилцлага хийж, ёс зүйтэй ажиллах, тулгарч буй бэрхшээлийг ярилцаж шийдвэрлэж ажиллаж байна.	
Гарсан үр дүн, ололт амжилт	Бэрхшээл
Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дэргэдэх Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, Төрийн албаны салбар зөвлөлөөс Төрийн албаны зөвлөлийн 30 жилийн ой, “Шинэчлэлээр түүчээлсэн-Төрийн алба” аяны хүрээнд Төрийн албаны тухай хууль, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хүрээнд төрийн байгууллагуудын ёс зүйн дэд хороодын дунд хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, мэтгэлцэх, багаар хамтран ажиллах ур чадварыг дээшлүүлэх зорилготой мэтгэлцээний тэмцээнд Гутгаар байранд Э.Баярмагнай ахлагчтай Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын баг шалгарсан.	-
Санал: байхгүй	

БАТАЛГААЖУУЛАЛТ:
Томилох эрх бүхий албан тушаалтан

Газрын харилцаа, барилга,
хот байгуулалтын
газрын дарга
/Албан тушаалтан/ */Гарын үсэг/* Б.ОТГОНЧИМЭГ
/Гарын үсгийн тайлал/

Ёс зүйн дэд хорооны дарга
_____ _____ Э.БАЯРМАГНАЙ
/Албан тушаалтан/ */Гарын үсэг/* */Гарын үсгийн тайлал/*

Ёс зүйн дэд хорооны нарийн бичгийн дарга
_____ _____ Д.ГАНЗОРИГ
/Албан тушаалтан/ */Гарын үсэг/* */Гарын үсгийн тайлал/*

Огноо 2025 оны 12 дугаар сарын 30

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН
ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗАР

Ардын өргөн чөлөөний 5 дугаар гудамж, 8 дугаар баг,
Дархан сум, Дархан-Уул аймаг, 45043
Утас/факс: (976) 7037-3770, 7037-6483
Цахим шуудан: Darkhan@gazar.gov.mn
Цахим хуудас: www.darkhan.gazar.gov.mn

2025.12.30 № 796

танай _____-ны № _____-т

ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ
ГЕОДЕЗИ ЗУРАГ ЗҮЙН ЕРӨНХИЙ ГАЗАРТ

Дархан-Уул аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн 2025 оны тайлан, Төрийн албан хаагчийн ёс зүйн асуудлаар гаргасан гомдол, мэдээлэл, түүний шийдвэрлэлтийн бүртгэлийн тайланг хүргүүлж байна.

Хавсралт 5 хуудастай.

ДАРГА Д.БАТЧУЛУУН

D:\Хулан\2025\Албан тоот\toot A5.796.doc

Ёс зүйн хорооны 2025 оны ... дүгээр
сарын ...-ний өдрийн ... дугаар тогтоолын
гуравдугаар хавсралт

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ГАЗРЫН ХАРИЛЦАА,
БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛЫН ГАЗРЫН
2025 ОНЫ ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ
ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН
"ТАЙЛАНГИЙН МАЯГТ"[1]

НЭГ. Товч танилцуулга[2]
Дархан-Уул аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын даргын 2024-09-05-ны өдрийн А/26 тоот тушаалаар 3 хүний бүрэлдэхүүнтэй байгуулагдсан. Ёс зүйн дэд хорооны дарга: Г.Нямдорж /Газрын удирдлагын хэлтсийн дарга/ Ёс зүйн дэд хорооны гишүүн: С.Цэвэлравжаа /Барилгын техникийн хяналтын улсын байцаагч/ Ёс зүйн хорооны нарийн бичгийн дарга: Э.Түмэнжаргал /Мэдээллийн технологийн асуудал хариуцсан мэргэжилтэн/
ХОЁР. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар
2.1.Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт[3]:
✓ Төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомжийг мөрдүүлж, ёс зүйтэй, шударга ажиллах талаар ойлголт, хандлага, соёлын өөрчлөлт бий болгоход чиглэсэн ажлын байран дахь сургалтыг 3 удаа зохион байгуулсан. ✓ Төрийн албанд анх томилогдсон албан хаагчдыг ёс зүйн чиглүүлэх сургалтад 1 удаа хамруулсан. ✓ "Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль"-аас байгууллагын олон нийтийн сүлжээгээр дамжуулан сурталчилсан. ✓ Ёс зүйн гомдол, мэдээлэл, зөрчил, хүлээлгэсэн хариуцлагын бүртгэлийг "Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцоо" цахим системд бүртгэн ажилласан.
2.2.Томилох эрх бүхий албан тушаалтны ёс зүйн манлайлал:
Төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомжийг чанд мөрдөн, ёс зүйтэй, ил тод, шударга харилцаа, хандлагаар албан хаагчийг үлгэрлэн манлайлж ажиллласан.

[1] Маягтын дагуу тайланг 5 хуудаснаас ихгүй, товч үр дүнг нэгтгэн ирүүлнэ.

[2] Байгууллагын харьяа салбар, нэгжийн хэмжээнд Төрийн албан хаагчийн ёс зүйн нийтлэг хэм хэмжээг сахиулах, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, зөрчил гаргасан эсэхийг хянан шалгаж, дүгнэлт гаргах, төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд дүн шинжилгээ хийх байдлын талаар товч мэдээллийг тайлагнана.

[3] Улсын Их Хурлын 2024 оны 27 дугаар тогтоолоор батлсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх хүрээнд зохион байгуулсан үйл ажиллагааны талаар тайлагнана.

2.3. Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа:
✓ Байгууллагын албан хаагчдад ёс зүйн талаар ажлын байран дээрх сургалтыг 3 удаа, анх удаа төрийн албанд томилогдож буй албан хаагчдыг чиглүүлэх сургалтад 1 удаа хамруулсан. ✓ Засгийн газрын "Олон нийттэй харилцах төв"ийн 11-11 тусгай дугаарт ирүүлсэн 1 гомдлыг хүлээн авч, цахим системд бүртгэж, ёс зүйн дэд хорооны хурлаар хэлэлцэн, шийдвэрлэж хариуг 2025-06-24-ний 368 дугаар албан тоотоор иргэнд хүргүүлсэн. ✓ Төрийн албан хаагчийн ёс зүйн асуудлаар гаргасан гомдол, мэдээлэл, түүний шийдвэрлэлтийн талаарх бүртгэлийн маягтын дагуу тайланг 2 удаа гаргаж, ГЗБГЗЗЕГ-ын ёс зүйн хороонд болон аймгийн ЗДТГ-ын ёс зүйн хороонд хүргүүлсэн.

Гарсан үр дүн, ололт амжилт:	Бэрхшээл:
2025 онд байгууллагын албан хаагчид ёс зүйн зөрчил гаргалгүй ажилласан.	Байхгүй.

Санал:
Ёс зүйн зөрчлийн бүртгэл, хяналт цахим системээс гарч буй тайлангийн загварыг "Төрийн албан хаагчийн ёс зүйн асуудлаар гаргасан гомдол, мэдээлэл, түүний шийдвэрлэлтийн талаарх бүртгэлийн маягт"-ын дагуу гарч ирдэг болгох

Шалгах хэсэг:

"Ёс зүй, сахилга хариуцлагын үнэлгээний шалгуур үзүүлэлт"-ийн дагуу үнэлгээ хийсэн эсэх.

Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтэд нийцүүлэн баталсан үйл ажиллагааны төлөвлөгөө хавсаргасан эсэх.

Байгууллагын 2025 оны Ёс зүйн дэд хорооны хууль тогтоомжийн хэрэгжилтийн тайланг маягтын дагуу бүрэн тайлагнасан эсэх.

БАТАЛГААЖУУЛАЛТ:

Томилох эрх бүхий албан тушаалтан:
Газрын дарга
/Албан тушаал/ _____ */Гарын үсэг/* Д.Батчулуун */Гарын үсгийн тайлал/*

Ёс зүйн дэд хорооны дарга
Газрын удирдлагын
хэлтсийн дарга
/Албан тушаал/ _____ */Гарын үсэг/* Г.Нямдорж */Гарын үсгийн тайлал/*

Ёс зүйн дэд хорооны нарийн бичгийн дарга
Мэдээллийн технологийн асуудал
хариуцсан мэргэжилтэн
/Албан тушаал/ _____ */Гарын үсэг/* Э.Түмэнжаргал */Гарын үсгийн тайлал/*

Огноо: 2025 оны 12 сарын 24

ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ГЕОДЕЗИ ЗУРАГ ЗҮЙН ЕРӨНХИЙ ГАЗАР
ДОРНОГОВЬ АЙМГИЙН ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗАР
ТБАГУТҮГ
Дорноговь аймаг, Сайншанд сум, 3-р баг Залуучууд 1-р гудамж 118 тоот
Утас: 70523988, Факс: 70523988
Цахим шуудан: dornogovi@gazar.gov.mn
Цахим хуудас: https://dornogovi.gazar.gov.mn/

2025.12.31 № 1081

танай -ны № -т

Г ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ЕРӨНХИЙ ГАЗАРТ Г

Байгууллагын ёс зүйн дэд хорооноос төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн 2025 оны тайланг батлагдсан шалгуур үзүүлэлт, маягтын дагуу гаргаж, хавсралтаар хүргүүлэв.

Хавсралт 5 хуудастай

Дорноговь аймгийн газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар
Захиргаа
Даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч
Лутбаяр Олзбаяр
2025-12-31 10:21:13

ДОРНОГОВЬ АЙМГИЙН ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

НЭГ. Товч танилцуулга	
Монгол улсын Ёс зүйн хорооны 2024 оны 05 дугаар тогтоолоор "Ёс зүйн дэд хорооны ажиллах журам" батлагдсаны дагуу байгууллагын Ёс зүйн дэд хороог 3 хүний бүрэлдэхүүнтэйгээр тус газрын 2024 оны А/47 дугаар тушаалаар шинэчлэн байгуулсан. Байгууллагын ёс зүйн дэд хорооноос 2025 онд 4 зорилтын хүрээнд 12 арга хэмжээг зохион байгуулахаар төлөвлөж, төлөвлөгөөг газрын даргаар батлуулан, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Байгууллагын ёс зүйн дээд хорооноос танхимын 2 сургалт, төрийн албан хаагч нийгмийг соён гэгээрүүлэгч байх, шударга, ёс зүйтэй харилцаа, хандлагатай холбоотой 8 зөвлөмж, чиглэл, мэдээллийг албан хаагчдын дундын мэдээллийн группээр дамжуулан өгч ажилласан бол шинээр томилогдсон 2 албан хаагчдад Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, байгууллагад мөрдөгдөж буй дүрэм, журмыг танилцуулсан. 2025 онд сахилгын шийтгэл оногдуулсан албан хаагч байхгүй.	
ХОЁР.Төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар	
2.1.Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт:	
Байгууллагын ёс зүйн дээд хорооноос танхимын 2 сургалт, төрийн албан хаагч нийгмийг соён гэгээрүүлэгч байх, шударга, ёс зүйтэй харилцаа, хандлагатай холбоотой 8 зөвлөмж, чиглэл, мэдээллийг албан хаагчдын дундын мэдээллийн группээр дамжуулан өгч ажилласан бол шинээр томилогдсон 2 албан хаагчдад Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, байгууллагад мөрдөгдөж буй дүрэм, журмыг танилцуулсан.	
2.2. Томилох эрх бүхий албан тушаалтны ёс зүйн мэдлэйлал:	
Газрын даргын 2024 оны А/47 дугаар захирамжаар ёс зүйн дэд хорооны гишүүдийг урамшуулах санхүүгийн эх үүсвэрийг шийдвэрлэсэн ба 2025 оны 1-р улирал нийт 2376.0 мянган төгрөгийн урамшууллыг гишүүдэд олгосон. Харин Байгууллагын ёс зүйн дэд хорооноос тавьсан хүсэлтийг дагуу ёс зүйн дэд хорооны мэдээллийн самбартай холбоотой 385.0 мянган төгрөгийн зардлын асуудлыг шийдвэрлэсэн.	
2.3.Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа:	
Байгууллагын ёс зүйн дэд хорооноос 2025 онд 4 зорилтын хүрээнд 12 арга хэмжээг зохион байгуулахаар төлөвлөж, төлөвлөгөөг газрын даргаар батлуулан, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Байгууллагын ёс зүйн дээд хорооноос танхимын 2 сургалт, төрийн албан хаагч нийгмийг соён гэгээрүүлэгч байх, шударга, ёс зүйтэй харилцаа, хандлагатай холбоотой 8 зөвлөмж, чиглэл, мэдээллийг албан хаагчдын дундын мэдээллийн группээр дамжуулан өгч ажилласан бол шинээр томилогдсон 2 албан хаагчдад Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, байгууллагад мөрдөгдөж буй дүрэм, журмыг танилцуулсан. Ёс зүйн дэд хорооны 2024 оны үйл ажиллагааны баталгаажуулсан тайланг Монгол улсын Ёс зүйн хороо болон аймгийн Засаг даргын Тамгын газрын дэргэдэх Ёс зүйн дэд хороонд 2025 оны 1-р сард тус тус хүргүүлэн ажилласан. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайлан, зөрчил шийдвэрлэлтийг цахим хуудсанд тухай бүр байршуулсан.	
Гарсан үр дүн, ололт амжилт	**Бэрхшээл**
Авлига, ашиг сонирхлын зөрчил, ёс зүй, сахилга хариуцлагатай холбогдсон хууль тогтоомжид заасан төрийн албан хаагчтай холбоотой эрх, үүргийг тайлбарлаж танилцуулах хуудсыг ойлгомжтой байдлаар боловсруулан, шинээр томилогдсон 2 албан хаагчид танилцуулан баталгаажуулсан.	Ёс зүйн хорооноос баталсан арга члалын дагуу байгууллага албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийг тооцох үнэлгээг хийхэд мэргэжил арга зүйн зөвлөгөөг дутмаг байгаагаас хийх боломжгүй байна.
Санал:	

Ёс зүйн хорооноос баталсан арга члалын дагуу байгууллага албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийг тооцох үнэлгээг хийхэд мэргэжил арга зүйн зөвлөгөө авах.

Шалгах хэсэг:

☐ "Ёс зүй, сахилга, хариуцлагын үнэлгээний шалгуур үзүүлэлт"-ийн дагуу үнэлгээ хийсэн эсэх.

☐ Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтэд нийцүүлэн баталсан үйл ажиллагааны төлөвлөгөө хавсаргасан эсэх.

☐ Байгууллагын 2025 оны Ёс зүйн дэд хорооны хууль тогтоомжийн хэрэгжилтийн тайланг маягтын дагуу бүрэн тайлагнасан эсэх.

БАТАЛГААЖУУЛАЛТ:

Томилох эрх бүхий албан тушаалтан

ДОРНОГОВЬ АЙМГИЙН ГХБХБГАЗРЫН ДАРГЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ ..... /Л.ОЛЗБАЯР/

Ёс зүйн дэд хорооны дарга

ГАЗАР, ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ХЯНАЛТЫН
УЛСЫН ХЯНАЛТЫН АХЛАХ БАЙЦААГЧ ..... /Д.ТӨМӨРБААТАР/

Ёс зүйн дэд хорооны нарийн бичгийн дарга

ГАЗРЫН ТАТВАР, ТӨЛБӨР, ҮНЭЛГЭЭНИЙ
АСУУДАЛ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН ..... /Н.ОЮУНГЭРЭЛ/

БАТЛАВ
ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА ХОТ
БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ҮЙЦЭТГЭГЧ
Л.ОЛЗБАЯР

2025 оны 1 сарын 17-ны өдөр

БАЙГУУЛЛАГЫН ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ 2025 ОНЫ ХИЙХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Хийгдэх ажил	Хугацаа	Шалгуур үзүүлэлт	Хариуцах албан хаагч
Нэг. Удирдлага зохион байгуулалт				
1.1	Ёс зүйн дэд хорооны 2025 оны төлөвлөгөөг батлуулах	1-р сард	Төлөвлөгөөний хэрэгжилтээр	Ёс зүйн дэд хороо
1.2	Ёс зүйн дэд хорооны хэвлэмэл хуудсыг хэвлүүлэх, ёс зүйн мэдээллийн санд нэвтрэх эрхийг нээлгэх	1-р сард	Хэвлэмэл хуудастай болж, нэвтрэх эрхийг нээлгэсэн байна.	Нарийн бичгийн дарга
1.3	Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа, гишүүдийг чадавхжуулахтай холбогдох зардлын асуудлыг шийдвэрлэх	Тухай бүр	Шийдвэрлэгдсэн зардал	Газрын дарга, ерөнхий нягтлан бодогч
Хоёр. Төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомжийг таниулах, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх				
2.1	Байгууллагын албан хаагчдад төрийн албан хаагчийн ёс зүйн талаарх хууль тогтоомжийг таниулах, зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалт зохион байгуулах	Улирал бүр	Сургалтын тоо -4, Хамрагдсан албан хаагчдын тоо	Ёс зүйн дэд хорооны дарга, гишүүд
2.2	Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм болон ажлын байранд дагаж мөрдөх хэм хэмжээ, дотоод журмын ёс зүйтэй холбоотой заалтуудыг албан хаагчдад танилцуулах, баталгаажуулах	Тухай бүр	Танилцсан албан хаагчдын тоо	Ёс зүйн дэд хорооны дарга, гишүүд
2.3	Шинээр ажилд орсон албан хаагчдад Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, шинээр ажилд орсон албан хаагчдад байгууллагад мөрдөгдөж буй дүрэм, журмыг танилцуулах	Тухай бүр	Танилцсан албан хаагчдын тоо	Ёс зүйн дэд хорооны дарга, гишүүд
2.4	Ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр бэлтгэсэн штрок, инфографик, нийтлэл, зураг хуудас, цахим ном,	Жилдээ	Түгээсэн тоо, давтамж, авсан хандалтын тоо	Ёс зүйн дэд хороо

	гарын авлага зэргийг тухайн орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, албан ёсны цахим хуудас болон нийгмийн сүлжээ /фэйсбүүк, твиттер, инстаграм, youtube суваг/, сурталчилгааны самбарт байршуулах зэрэг бүхий л боломжтой хэлбэрээр олон нийтэд хүргэх			
Гурав.Зөрчил гаргасан эсэхийг хянан шалгаж, дүгнэлт гаргах, төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд дүн шинжилгээ хийх				
3.1	Албан хаагчдын сахилга, ёс зүйтэй холбоотой ирсэн гомдлыг хэлэлцэж шийдвэрлэх, дүгнэлт гаргах, хүргүүлэх	Тухай бүр	Шийдвэрлэлтийн хувь	Ёс зүйн дэд хороо
3.2	Байгууллага, нэгж дотор гарч байгаа болон үүсэж болзошгүй ёс зүйн зөрчилд дүн шинжилгээ хийх, шалтгаан нөхцөл, эрсдлийг тодорхойлж, зөвлөмж чиглэлийг хүргүүлэх	Хүргүүлсэн зөвлөмжийн тоо	Хүргүүлсэн зөвлөмжийн тоо	Ёс зүйн дэд хорооны дарга, гишүүд
Дөрөв. Мэдээллэх тайлагнах				
4.1	Ёс зүйн зөрчил, холбогдох гомдол, мэдээлэл, шийдвэрлэлт, тэдгээрт хүлээлгэсэн хариуцлагын талаарх мэдээлэл, үйл ажиллагааны тайланг цахим систем болон байгууллагын цахим хуудсанд байршуулах	Тухай бүр	Оруулсан мэдээллийн тоо	Нарийн бичгийн дарга
4.2	Албан хаагчийн ёс зүйн зөрчилтэй холбогдох тайлан, мэдээг хүргүүлэх	Улирал бүр	Хүргүүлсэн тайлан, мэдээний тоо	Ёс зүйн дэд хороо
4.3	Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагааны тайланг Ёс зүйн хороонд хүргүүлэх	Дараа оны 1 дүгээр сарын 05-ны дотор	Тайлан хүргэгдсэн байна.	Ёс зүйн дэд хороо

-oo0oo-

ДОРНОД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ АГЕНТЛАГ
ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА,
ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗАР

Хэрлэн сумын ЗДТГ-ын 1 давхар, Х.Чойбалсангийн гудамж 7-704,
6 дугаар баг, Хэрлэн сум, Дорнод аймаг, 21060,
Утас: 7058-2501
Цахим шуудан: dornod@gazar.gov.mn
Цахим хуудас: www.dornod.gazar.gov.mn

2025. 12. 30 № 1/1170

танай 2025. 12. 23-ны № 2/4046 -т

ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ГАЗРЫН ДАРГА Б.ЭНХБОЛД ТАНАА

Тус газраас Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн тайланг батлагдсан шалгуур үзүүлэлт, маягтын дагуу бэлтгэн хүргүүлэв.

Хавсралт 2 хуудастай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Х.ГҮЕНБАТ

2025.12.30 №1/1170 тоот цахимаар хүргүүлэв.
Хөтлөх хэрэг №10-д

2106106360

E:\My documents\ bichig hereg\ A-5 alban bichig

Ёс зүйн хорооны 2025 оны 12 дугаар
сарын 01-ний өдрийн 09 дүгээр тогтоолын
гуравдугаар хавсралт

БАЙГУУЛЛАГЫН 2025 ОНЫ ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

НЭГ. Товч танилцуулга

Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын даргын 2023 оны Б/10 дугаар тушаалаар тус газрыг 39 орон тоотой байхаар баталсан. 2025 оны жилийн эцсийн байдлаар 29 албан хаагч ажиллаж байна. Тайлант хугацаанд сул орон 8 байна. Мөн хүүхэд асрах чөлөөтэй 3 албан хаагч байна.

Газрын даргын 2025 оны А/36 дугаар тушаалаар байгууллагын ёс зүйн дэд хороог 3 хүний бүрэлдэхүүнтэйгээр шинэчлэн байгуулсан.

Тус газрын ёс зүйн дэд хорооноос иргэд олон нийтээс байгууллагын албан хаагчдын ёс зүйн хэм хэмжээтэй холбоотой өргөдөл, гомдол, санал хүсэлтийг хүлээн авахаар yoszui.ghbhbg@dornod.gazar.gov.mn цахим хаягийг ажиллуулж байна.

Тайлант оны жилийн эцсийн байдлаар иргэн аж ахуйн нэгж байгууллагаас цаасаар болон цахим программаар нийт 756 албан бичиг, 150 өргөдөл гомдол ирүүлснийг бүртгэл хөтөлж, газрын даргаар цохолт хийлгэн холбогдох албан хаагчдад шилжүүлэн хариуг хугацаанд нь хүргүүлэн ажилласан.

Тус газраас жилийн эцсийн байдлаар буюу 11 дүгээр сарын 20-ны өдрийн байдлаар 1032 албан бичгийг гарган холбогдох иргэн аж ахуйн нэгж байгууллагууд болон дээд шатны байгууллагууд болох ХББОСЯ, ГЗБГЗЗЕГ, БХТ, АЗДТГ-т тус тус хүргүүлэн ажилласан.

Мөн өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн тайлан мэдээг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэст 1/52, 1/134, 1/215, 1/348, 1/430, 2/573, 1,812 тоот албан бичгүүдээр сар, улирал бүр хугацаанд нь хүргүүлэн ажилласан. Байгууллагын албан хаагчдын ёс зүйн зөрчлийн талаар гомдол мэдээлэл ирээгүй болно.

ХОЁР. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар

2.1. Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт:

Тайлант хугацаанд тус байгууллагад 39 албан хаагч ажиллахаас 29 албан хаагч ажилласан.

Ёс зүйн хорооны 2025 оны 06 дугаар тогтоолоор батлагдсан албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийг тооцох үнэлгээг хийж ажилласан. Эрсдэлийн үнэлгээний матрицаар "Иргэдтэй харилцах байдал"-д эрсдэл "өндөр" гэж гарсан. Дээрх үзүүлэлтийн дагуу албан хаагчдаас "Ёс зүйн нөлөөллийн мэдүүлэг"-ийг гаргуулан авсан.

Төрийн албан хаагчдад зориулсан "Ёс зүй" 1, 2, 3 дугаар түвшний цахим сургалтад нийт 7 албан хаагч хамрагдаж, гэрчилгээ авсан.

Мөн Хэнтий аймагт зохион байгуулагдсан "Бүсчилсэн хөгжил – Төрийн албаны манлайлал" зүүн бүсийн зөвлөгөөнд 2 албан хаагчийг хамруулсан.

2.2. Томилох эрх бүхий албан тушаалтны ёс зүйн манлайлал:

Тайлант хугацаанд байгууллагын албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтод өөрчлөлт оруулах саналыг Газрын даргын 2025 оны 1/315, байгууллагын бүтэц, орон тоонд өөрчлөлт оруулах саналаа 2/552, 1/1074 тоот албан бичгээр, сул орон тооны захиалгыг 1/300, 2/554, 1/891, 1/944, 4/1044 тоот албан бичгээр тус тус ГЗБГЗЗЕГ-т хүргүүлэн ажилласан.

Тайлант хугацаанд шинээр томилогдсон 6, шилжүүлэн томилсон 3, чөлөөлсөн 5 албан хаагч байна. Нийт 7 албан хаагчийг хуулийн дагуу нөхөн томилсон, үүнээс тусгай шалгалтын дүнгээр тогтоолын дагуу шинээр томилогдсон 4, шилжүүлэн томилсон 3, нөөцөөс нөхөн томилсон 1 байна. Тайлант хугацаанд 1 албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулсан.

Хүний нөөцийн ажилтны өдрийг тохиолдуулан аймгийн "Dornod HR" клубтэй хамтран хуваарийн дагуу ШШГГ, ГБХХГ-ын албан хаагчдын хамт Хэрлэн сумын 11 дүгээр сургуулийн 9-12 дугаар ангийн сурагчдад Монгол төрийн залгамж чанар, төрийн албаны үнэ цэний талаар ойлголт, мэдээлэл өгч ажилласан. Үүнд:

Төрийн албаны үнэ цэнэ, хариуцлагын талаарх ойлголт

Төрийн албанд ажиллах боломж, давуу тал

Орон нутгийн тэтгэлэгт хөтөлбөрийн талаарх мэдээлэл /газрын даамал/
Төрийн албаны залгамж чанар, ирээдүйн боловсон хүчин бэлтгэх

2.3. Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа:

Газрын даргын 2022 оны А/06 дугаар тушаалаар тус байгууллагад шинээр томилогдсон албан хаагчдад ажлын чиг баримжаа олгох, байгууллагын соёл, үйл ажиллагаанд дадлагажуулах хөтөлбөрийг боловсруулан, баталж хэрэгжилтийг ханган ажиллаж байна.
Тайлант хугацаанд дээрх хөтөлбөрт 5 албан хаагчийг хамруулсан. Хөтөлбөрийн хүрээнд албан хаагчдад байгууллагын танилцуулга, бүтэц зохион байгуулалт болон байгууллагын дэргэдэх ажлын хэсэг, зөвлөл, дотоод журмын талаарх мэдээллийг бэлтгэн хүргэж байна.
Мөн Төрийн албаны тухай хууль болон түүнтэй холбогдон гарсан дүрэм журмууд, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийг тус тус танилцуулж ажилласан.
Газрын даргын А/09 дүгээр тушаалаар "Газрын харилцааны ажилтны өдөр"-ийг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хэсэг байгуулагдан, тус өдрийг угтан зохион байгуулах арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан батлуулсан. Тус төлөвлөгөөний дагуу сумдын Газрын даамлуудад 2025 оны 05 дугаар сарын 08-09-ний өдрүүдэд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, чадавхжуулах сургалтыг зохион байгуулсан. Уг үйл ажиллагаанд байгууллагын дүгээс 1505,3 мянган төгрөгийг зарцуулсан.
"Шинэ эрин" сургалтын төвтэй хамтран албан хаагчдын харилцаа хандлага, хууль эрх зүйн мэдлэг чадварыг дээшлүүлэх 4 цагийн сургалтад нийт албан хаагчдыг хамруулсан.

Гарсан үр дүн, ололт амжилт:	**Бэрхшээл:**
1. Сургалтын үйл ажиллагааг мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулснаар албан хаагчдын идэвх оролцоо нэмэгдсэн 2. Бусад байгууллагатай хамтран ажиллаж байгууллагын үйл ажиллагааны талаарх мэдээллийг иргэдэд ил тод нээлттэй түгээн дэлгэрүүлж ажилласан.	1. Ёс зүйн дэд хорооны гишүүдэд олгох урамшууллын зардал байхгүй. 2. Сургалтын болон бусад үйл ажиллагаанд зарцуулах төсөв байхгүй.

Санал:

1. Байгууллагын ёс зүйн дэд хорооны гишүүдэд урамшууллыг олгох
2. Ёс зүйн сургалт нөлөөллийн арга хэмжээ тогтмол зохион байгуулах
3. Байгууллагын цахим үйлчилгээний талаар иргэд олон нийтэд сурталчлан таниулах
4. Албан хаагчдыг сэтгэл зүйн сургалтад хамруулах, мэргэжлийн сэтгэл зүйчээс зөвлөгөө, мэдээлэл авах боломж бололцоог бүрдүүлэх

БАТАЛГААЖУУЛАЛТ:

Томилох эрх бүхий албан тушаалтан
Дорнод аймгийн ГХБХБГ-н даргын
албан үүргийг түр орлон гүйцэтгэгч ..... Х.Гүенбат
(Албан тушаал) (Гарын үсэг) (Гарын үсгийн тайлал)

Ёс зүйн дэд хорооны дарга
Хяналт шалгалтын хэлтсийн дарга ..... Г.Баярмаа
(Албан тушаал) (Гарын үсэг) (Гарын үсгийн тайлал)

Ёс зүйн дэд хорооны нарийн бичгийн дарга
Захиргаа, хуулийн асуудал хариуцсан
ахлах мэргэжилтэн ..... Д.Гэрэлмаа
(Албан тушаал) (Гарын үсэг) (Гарын үсгийн тайлал)

Огноо: 2025 оны 12 сарын 30

ДУНДГОВЬ АЙМГИЙН ГАЗРЫН ХАРИЛЦАА,
БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗАР
Г.Чагдаржавын гудамж 1-101 тоот, Нарлаг баг,
Сайнцагаан сум, Дундговь аймаг, 48090
Утас: 7059-2555, Факс: 7059-2555
Цахим шуудан: dundgovi@gazar.gov.mn
Цахим хуудас: dundgovi.gazar.gov.mn

2025.12.25 № 1/634

танай 2025.12.23 -ны № 2/4046 -т

Г ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ГАЗАРТ Т

Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль болон Монгол Улсын Их Хурлын 2024 оны 27 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр"-ийн 2025 оны хэрэгжилтийг Ёс зүйн хорооны 2025 оны 09 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлагдсан "Ёс зүй, сахилга хариуцлагын үнэлгээний шалгуур үзүүлэлт", гуравдугаар хавсралтаар батлагдсан "Тайлангийн маягт"-ын дагуу гаргаж хавсралтаар хүргүүлэв.

Хавсралт 6 хуудастай.



Дундговь аймгийн газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар
Захиргаа удирдлагын хэлтэс
Газрын дарга
Эрдэнэцэцэг Чагнаадорж
2025-12-25 18:18:13

БАЙГУУЛЛАГЫН 2025 ОНЫ ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН "ТАЙЛАНГИЙН МАЯГТ"[1]

НЭГ. Товч танилцуулга[2]

Хуулиар тогтоосон ёс зүйн хэм хэмжээг сахих, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн тухай гомдол, мэдээллийг холбогдох хууль тогтоомжийн дагуу хянан шийдвэрлэх, төрийн албан хаагчдын мэргэжлийн ёс зүйг мөрдөж, иргэдэд үзүүлж буй төрийн үйлчилгээний чанарыг сайжруулах, аливаа зөрчил, гажуудлаас сэргийлэх үйл ажиллагааг зохион байгуулах зорилгоор тус байгууллагын даргын 2023 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн А/11 дүгээр тушаалаар Ёс зүйн дэд хороог 3 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулж, ажиллах журмыг хавсралтаар баталсан.

2025 онд тус байгууллагын Ёс зүйн дэд хороо 2 удаа хуралдсан ба хуралдаанаар 2025 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний төслийг хэлэлцэж, 8 арга хэмжээг төлөвлөн үе шаттайгаар хэрэгжүүлэхээр шийдвэрлэж, тус байгууллагын даргаар 2025 оны 02 дугаар сарын 04-ний өдөр батлуулан төлөвлөгөөг албан хаагчдад танилцуулсан.





Тус байгууллагын Ёс зүйн дэд хорооноос Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3.4 дэх заалт "хариуцсан салбар, байгууллага, нэгж дотроо гарч байгаа болон үүсэж болзошгүй ёс зүйн зөрчилд дүн шинжилгээ хийх, шалтгаан, нөхцөл, эрсдэлийг тооцох, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлыг төлөвлөн зохион байгуулах"-ын хүрээнд ажлын байран дээрх сургалтын үеэр албан хаагчдад дараах арга хэмжээг зохион байгуулсан. Үүнд:

- Төлөвлөгөөнд тусгагдсны дагуу төрийн албан хаагчийн ёс зүйн зарчим, нийтлэг хэм хэмжээг сахиулах, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор Газрын даамлуудыг чадахижуулах сургалтын үеэр нийт албан хаагчдад "Төрийн албан хаагчийн ёс зүй" сэдвээр Төрийн албаны салбар зөвлөлийн Нарийн бичгийн дарга А.Одончимэг сургалт зохион байгуулсан. Сургалтад нийт 25 албан хаагч хамрагдсан.

---

[1] Маягтын дагуу тайланг 5 хуудаснаас ихгүй, товч үр дүнг нэгтгэн ирүүлнэ.

[2] Байгууллагын харьяа салбар, нэгжийн хэмжээнд Төрийн албан хаагчийн ёс зүйн нийтлэг хэм хэмжээг сахиулах, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, зөрчил гаргасан эсэхийг хянан шалгах, дүгнэлт гаргах, төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд дүн шинжилгээ хийх байдлын талаар товч мэдээллийг тайлагнана.





- “Төрийн албан хаагчийн ёс зүйн нийтлэг хэм хэмжээ”, “Төрийн албан хаагчид тавигдах нийтлэг шаардлага”, “Төрийн албан хаагчийн ёс зүй” сэдэвт сургалтуудыг тус тус зохион байгуулсан ба сургалтад тус байгууллагын 20 албан хаагч бүрэн хамрагдсан.





- Иргэдээс авсан хэрэглэгчийн үнэлгээний санал асуулгаар албан хаагчдын ёс зүйтэй холбоотой санал гараагүй ба түргэн шуурхай үйлчлэхэд анхаарах талаар 1 иргэнээс санал ирсэн. Мөн төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийн үнэлгээгээр “Иргэдтэй харилцах байдал эрсдэлийн хүрээнд” 6 албан хаагч өндөр эрсдэлтэй гэж үнэлсэн ба бусад төрийн байгууллагуудтай харьцуулахад иргэд байнга үйлчлүүлдэг, байгууллагын үндсэн үйл ажиллагаа нь хувь хүний болон байгууллагын нууцын асуудалд хамаардаг, иргэдийн эрх ашгийг хөндсөн асуудал их байдаг тул албан хаагчдыг хувь хүний харилцаа хандлагын сургалтад хамруулах, идэвхижүүлэх зөвлөмжийг тайланд тусгасан. Дээрх ажлын хүрээнд “Харилцааны ур чадвар” сэдэвт хувь хүний сургалтыг байгууллагын Ёс зүйн дэд хорооноос байгууллагын нийт албан хаагчдад 2025 оны 12 дугаар сарын 17-ны өдөр зохион байгуулсан.






ХОЁР. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар

2.1. Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хетөлбөрийн хэрэгжилт[3]:

Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн зорилго 1-ийн хүрээнд Ёс зүйн хорооны 2025 оны 09 дүгээр сарын 26-ны өдрийн 06 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралтаар батлагдсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийн үнэлгээний хуудас"-аар авсан ба нийт 29 албан хаагчаас 24 албан хаагч үнэлгээнд хамрагдсан ба үнэлгээг дээрх тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлагдсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийг тооцох үнэлгээний аргачлал"-ын дагуу эрсдэлийн түвшинг тодорхойлж, эрэмбэлсэн.

ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН ЁС ЗҮЙН ЗӨРЧИЛД ӨРТӨХ ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ЭРЭМБЭ

Нөлөөлөл (С) Магадлал (Р)	1	2	3	4	5	6	7	8	9
1	1	1	12	11	1	1	1	1	1
2	2	6	1	4	1	1	1	1	1
3	1	2	1	2	1	1	1	1	1
4	3	3	2	5	4	2	5	4	2
5	1	1	15	1	1	2	1	1	1
6	1	17	22	14	1	5	1	1	1
7	1	4	1	4	1	1	1	1	1
8	2	5	6	4	1	1	1	1	1
9	2	8	6	6	1	2	1	1	1
10	1	3	19	7	1	1	1	1	1
11	2	1	10	7	1	1	1	1	1
12	1	16	1	1	1	1	1	1	1
13	1	17	1	5	1	1	1	1	1
14	2	2	3	10	1	1	1	1	1
15	1	4	17	7	1	1	1	1	1
16	2	1	13	13	5	1	1	1	1
17	1	2	4	4	1	1	1	1	1
18	4	3	25	9	1	1	1	1	1
19	2	5	9	9	1	1	1	1	1
20	1	3	10	2	5	1	1	1	1
21	1	1	22	13	1	1	1	1	1
22	1	6	13	11	1	1	1	1	1
23	5	19	22	11	1	2	1	1	1
24	1	5	14	5	1	1	1	1	1





[3] Улсын Их Хурлын 2024 оны 27 дугаар тогтоолоор батлсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх хүрээнд зохион байгуулсан үйл ажиллагааны талаар тайлагнана.

Эрсдэлд авах хариу арга хэмжээний зөвлөмжийг тайланд тусган байгууллагын удирдлагад танилцуулсан ба тайланг Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газар болон аймгийн Засаг даргын тамгын газарт тус тус хүргүүлсэн.


ДУНДГОВЬ АЙМГИЙН ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗАР

2025.11.25 № 1/555

танай 2025.11.04 -ны № 02/1507 -т

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАРТ

Ёс зүйн хорооны 2025 оны 09 дүгээр сарын 26-ны өдрийн 06 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийг тооцох үнэлгээний аргачлал"-ын дагуу тус байгууллагын албан хаагчдын ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийн үнэлгээг зохион байгуулж, холбогдох тайланг хавсралтаар хүргүүлэв.

Хувийг Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газарт

Хавсралт 4 хуудастай.

Дундговь аймгийн газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар
Захиргаа удирдлагын хэлтэс
Газрын дарга
Эрдэнэцэцэг Чагнаадорж
2025-11-25 19:48:39

Мөн ёс зүйтэй иргэдээр төрийн албаны хүний нөөцийг бүрдүүлэх, албан хаагчдыг ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх зорилгоор ажлын байран дээрх сургалтуудыг тогтмол зохион байгуулдаг ба Ёс зүйн дэд хорооноос зохион байгуулсан ажлын тайланг улирал бүр албан хаагчдад тайлагнаж сонсгол хийж хэвшсэн.


Ингэснээр ёс зүй, сахилга хариуцлагатай албан хаагчдыг бэлтгэж, харилцаа хандлагаараа бусад төрийн албан хаагчдаа манлайлж, ёс зүйтэй хамт олонг бий болгох байгууллагын соёлыг дээшлүүлж байна.

Тайлант хугацаанд иргэдээс тус байгууллагын албан хаагчдын ёс зүйтэй холбоотой өргөдөл гомдол гараагүй.

2.2. Томилох эрх бүхий албан тушаалтны ёс зүйн манлайлал:

Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль болон Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх, төрийн албыг иргэдэд хүнд сурталгүй, түргэн шуурхай хүргэх, байгууллагын үйл ажиллагааг ил тод, нээлттэй мэдээллэх чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

“Нээлттэй мэдээллийг цахим хэлбэрээр байршуулж нийтлэх, шинэчлэх, хяналт тавих нийтлэг журам”-ын нийтэд ил тод мэдээллэх 87 арга хэмжээний хүрээнд Төрийн байгууллагын нэгдсэн цахим хуудас www.gov.mn–д тус байгууллагад хамааралтай арга хэмжээг байгууллагын хамаарах хэсэгт хөгжүүлэлт хийж, байршуулсан бөгөөд дээрх мэдээ, мэдээллийг мэдээллийн самбарт ил тод байршуулсан. Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газраас хийгдсэн нээлттэй мэдээллийн ил тод байдлын I, II, III улирлын үнэлгээгээр 100 хувьтай дүгнэгдсэн.



2.3. Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа:

- 2025 оны арга хэмжээний төлөвлөгөөг хамт олны хурлаар танилцуулж байгууллагын “Мэдээллийн самбар” болон www.dundgovi.gazar.gov.mn хуудасны “Үйл ажиллагааны ил тод байдал” хэсэгт, төрийн байгууллагын нэгдсэн цахим хуудас www.gov.mn, www.e-mongolia.mn цахим хуудсанд олон нийтэд ил тод мэдээллэж, сурталчилж байна.

Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан Ёс зүйн зөрчлийн бүртгэл хяналтын системд ажиллах цахим сургалтад Ёс зүйн хорооны Нарийн бичгийн дарга Д.Болорчимэг хамрагдсан ба системд ёс зүйн дэд хорооны бүртгэлийг үүсгэж, 2025 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг оруулж, баталгаажуулсан ба системд Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагааны хүрээнд 12 арга хэмжээ, сургалтын чиглэлээр 5 арга хэмжээ төлөвлөж, 100 хувь хэрэгжүүлсэн.



Гарсан үр дүн, ололт амжилт:	Бэрхшээл:
1. Шинээр томилогдсон албан хаагчдад Ёс зүйн тухай сургалт орж, Ёс зүйтэй төрийн албан хаагч байхаа баталсан БАТАЛГАА гардуулан өгсөн. 2. Байгууллагын нийт 13 албан хаагчаас Ёс зүйн зөрчилд өртөх эрсдлийн судалгаа хийж, үр дүнг холбогдох байгууллагад хүргүүлсэн. 3. Нийт 18 албан хаагчаас Ёс зүйн нөлөөллийн мэдүүлэг авч баталгаажуулсан.	
2.3 Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа	
Гарсан үр дүн ололт, амжилт:	Бэрхшээл:
1. Ёс зүйн дэд хорооны ханийн самбартай болсон.	1. Ёс зүйн дэд хорооны урамшуулал байнгын бус тул дэмжлэг байхгүй.

2. Ёс зүйн тухай хуулийн ойлголтыг бүх албан хаагчид хүргүүлсэн. 3. Шинээр томилогдсон албан хаагчдад анхан шатны чиглүүлэх сургалт орж хэвшсэн. 4. Албан хаагчид болон иргэд Ёс зүйн дэд хороонд хандаж гомдлоо шийдүүлэх, зөвлөгөө мэдээлэл авах нь ихэссэн. 5. Албан хаагчдын оролцоо нэмэгдсэн. 6. Ёс зүйн дэд хорооны гишүүд байнгын мэдээлэл, судалгаа хийх чадвар дээшилсэн.	2. Албан хаагчдын дунд Ёс зүйн дэд хороо зөвхөн хариуцлага тооцдог хороо гэсэн ойлголт бий болсон. 3. Шалгагдсан албан хаагчдаас сөрөг сэтгэгдэл ирүүлсэн.
Санал:	
1. Ёс зүйн дэд хороог байнгын үйл ажиллагаатай байлгахын тулд гишүүдийн урамшууллыг заавал өгөх тогтолцоог бий болгож байгууллагын удирдлагад мэдэгдэх 2. Ёс зүйн дэд хорооны тайланг хагас, бүтэн жилээр татан хянаж үнэлгээ тавин, зөвлөмжийн хамт салбар Ёс зүйн дэд хороонд хүргүүлж байх	

Шалгах хэсэг:

- ✓ “Ёс зүй, сахилга хариуцлагын үнэлгээний шалгуур үзүүлэлт”-ийн дагуу үнэлгээ хийсэн эсэх.
- ✓ Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтэд нийцүүлэн баталсан үйл ажиллагааны төлөвлөгөө хавсаргасан эсэх
- ✓ Байгууллагын 2025 оны Ёс зүйн дэд хорооны хууль тогтоомжийн хэрэгжилтийн тайланг маягтын дагуу бүрэн тайлагнасан эсэх

БАТАЛГААЖУУЛАЛТ:

Газрын харилцаа, барилга,
хот байгуулалтын газрын дарга — П.Золжаргал

Ёс зүйн дэд хорооны дарга
Хяналт, шалгалтын хэлтсийн дарга — Л.Эрдэнээ

Ёс зүйн дэд хорооны нарийн бичиг — Б.Хонгорзул

Огноо: 2025 оны 12 сарын 30

БАЙГУУЛЛАГЫН 2025 ОНЫ
"ЁС ЗҮЙ, САХИЛГА ХАРИУЦЛАГЫН ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ"

№	Үзүүлэлт	Шалгуур үзүүлэлт		Авбал зохих оноо	Оноо	Хувийн жин
1	2	3		4	5	6
1	Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт	Үйл ажиллагааны төлөвлөгөөг шалгуур үзүүлэлттэй нийцүүлэн баталсан эсэх		1	0,5	5%
2		Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдлийн үнэлгээ хийсэн эсэх		1	1	10%
3		Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлсэн байдал	Ёс зүйн сургалтыг 2-оос доошгүй удаа батлагдсан агуулгын хүрээнд зохион байгуулсан эсэх	0,5	0,5	5%
			Соён гэгээрүүлэх, нөлөөллийн ажил зохион байгуулсан эсэх	0,5	0,5	5%
			Ёс зүйн нөлөөллийн мэдүүлэг гаргасан байдал	0,5	0,5	5%
			Ёс зүйн зөрчлийн хариуцлагын бүртгэлийн маягт бөглөсөн байдал	0,5	0,4	4%
Хэсгийн оноо				**4**	**3,4**	**34%**
4	Томилох эрх бүхий албан тушаалтны ёс зүйн манлайлал	Ёс зүйн дэд хорооны дүгнэлтийг үндэслэн шийдвэр гаргасан эсэх		1	1	10%
5		Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайлан, зөрчлийн шийдвэрлэлтийг цахим хуудсанд байршуулсан байдал		1	0,5	5%
6		Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа, гишүүдийг урамшуулах санхүүгийн эх үүсвэрийг шийдвэрлэсэн байдал		1	0,5	5%
Хэсгийн оноо				**3**	**2**	**20%**
7	Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа	Дэд хорооны бүрэлдэхүүн хөдөлгөөнийг бүртгэсэн байдал		1	1	10%
8		Төрийн албан хаагчаас ирүүлсэн гомдол мэдээллийг шийдвэрлэсэн байдал		1	1	10%

9		Ёс зүйн зөрчлийн бүртгэл, хяналтын дэд систем дэх дүгнэлт, шийдвэрийг бүртгэж, тайлагнасан байдал	1	0,9	8%
Хэсгийн оноо			**3**	**2,6**	**26%**
Үнэлгээний нийт оноо, хувь			**10**	**8**	**80%**

БАТЛАВ
ХЯНАЛТ, ШАЛГАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА Л.ЭРДЭНЭЭ

ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН
“ЁС ЗҮЙН ДЭД ХОРОО”-НЫ 2025 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

2025.02.02

Даланзадгад сум

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Хариуцах албан тушаалтан
1	Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээнд тогтмол хяналт тавьж, холбогдох хууль, журмын хэрэгжилтийг хангах арга хэмжээг бодитой зохион байгуулах	I-XII	Ёс зүйн дэд хороо
2	Төрийн албаны ажил үйлчилгээнд иргэдэд ялгавартай хандахгүй аливаа ашиг сонирхлоос ангид байж, ил тод шуурхай байдлыг эрхэмлэх	I-XII	Ёс зүйн дэд хороо
3	Төрийн албан хаагч ёс зүйн зөрчил гаргасан нь тогтоогдсон бол ёс зүйн хариуцлага хүлээлгэсэн шийдвэрийн мэдээллийг нээлттэй байршуулж, ЗДТГ-ын Хууль, эрх зүйн хэлтэст ирүүлж байх.	I-XII	Ёс зүйн дэд хорооны нарийн бичиг
4	“Ёс зүйтэй төрийн албан хаагч” сургалт зохион байгуулах	I-XII	Ёс зүйн дэд хороо
⑤	Ёс зүйн дэд хорооны ханын самбартай болох	I-XII	Ёс зүйн дэд хороо
⑥	Төрийн албан хаагчийн ёс зүйн сэтгэл ханамжийн судалгаа авах	I-XII	Ёс зүйн дэд хороо
7	Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг зөрчсөнөөр үүсэх үр дагаврын тухай А3 ханын гар зурагийг уралдаан зохион байгуулах	I-VI	Ёс зүйн дэд хороо
⑧	Төрийн албаны зөвлөлөөс Ёс зүйн сургалт авах	I-XII	Ёс зүйн дэд хороо
9	Ёс зүйтэй Төрийн албан хаагч шалгаруулах	I-XII	Ёс зүйн дэд хороо
10	Төрийн албан хаагчийн ёс зүй сэдэвт мэдээлэл хүргэх	I-VI	Ёс зүйн дэд хороо

ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛСАН:
ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ НАРИЙН БИЧИГ Б.ХОНГОРЗУЛ

ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН
“ЁС ЗҮЙН ДЭД ХОРОО”-НЫ 2025 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ

2025.11.11 Даланзадгад сум

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Хэрэгжилт
1	Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээнд тогтмол хяналт тавьж, холбогдох хууль, журмын хэрэгжилтийг хангах арга хэмжээг бодитой зохион байгуулах	Зохион байгуулсан арга хэмжээний тоо	Төрийн албан хаагчийн ёс зүйд хяналт тавих арга хэмжээний хүрээнд “Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ” сэдэвт танилцуулга бэлтгэн И-оффис цахим системээр албан хаагчдад хүргүүлсэн. **Хавсралт 1** Бүсчилсэн хөгжил ТАЗ-аас зохион байгуулсан Ёс зүйн зөвөлгөөнд хамрагдсан. **Хавсралт 2**
2	Төрийн албаны ажил үйлчилгээнд иргэдэд ялгавартай хандахгүй аливаа ашиг сонирхлоос ангид байж, ил тод шуурхай байдлыг эрхэмлэх	Зохион байгуулсан арга хэмжээний тоо	Иргэдийн сэтгэл ханамжийн судалгааг авч үр дүнг нэгтгэсэн. **Хавсралт 3** Иргэдэд үзүүлж буй үйлчилгээний мэдээллийг мэдээллийн самбар болон цахим хэрэгслээр хүргүүлэн ажилласан. **Хавсралт 4**
3	Төрийн албан хаагч ёс зүйн зөрчил гаргасан нь тогтоогдсон бол ёс зүйн хариуцлага хүлээлгэсэн шийдвэрийн мэдээллийг нээлттэй байршуулж, ЗДТГ-ын Хууль, эрх зүйн хэлтэст ирүүлж байх.	Мэдээллийн тоо	2025 оны байдлаар Ёс зүйн дэд хороо дүгнэлт гарган, газрын дарга хариуцлага хүлээлгэх эрх зүйн акт гарган холбогдох байгууллагад 2025 оны 06 дугаар сарын 02 өдрийн 255 тоот албан бичгээр хүргүүлсэн. **Хавсралт 5**
4	“Ёс зүйтэй төрийн албан хаагч” сургалт зохион байгуулах	Сургалтын тоо	2025 оны 04 сарын 11-ний өдөр ГХБХБГ-ын нийт 27 албан хаагчид Өмнөговь аймгийн ТАСЗ-ын нарийн бичиг С.Баярнасан “Төрийн албан хаагчийн ёс зүй” сэдэвт сургалтыг зохион байгуулсан. **Хавсралт 6**
5	Ёс зүйн дэд хорооны ханын самбартай болох	Хийгдсэн эсэх	2025 оны байгууллагын Ёс зүйн дэд хороо байгууллагын Ёс зүйн дэд хорооны ханын самбарыг хийсэн. Тус ханын самбар Талархалын мод, дэд хорооны гишүүдийг

			танилцуулга, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, сэтгэл ханамжийн судалгааны хэсэг, Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ зэрэг агуулгыг багтааснаараа онцлогтой. **Хавсралт 7**
6	Төрийн албан хаагчийн ёс зүйн сэтгэл ханамжийн судалгаа авах	Судалгааны үр дүн	Иргэдийн сэтгэл ханамжийн судалгааны үр дүнд харилцаа хандлага 3 оноо, Төрийн албан чанар хүртээмж үйлчилгээ 1 оноо авсан байна.
7	Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг зөрчсөнөөр үүсэх үр дагаврын тухай А3 ханын гар зургийн уралдаан зохион байгуулах	Зохион байгуулсан арга хэмжээний тоо	2025 оны 04 дүгээр сарын 22-ны өдрөөс 05 дугаар сарын 09-ны өдрийн хооронд байгууллагын нийт 4 хэлтсийн дунд "Төрийн албан хаагчийн ёс зүй бидний нүдээр" сэдэвт гар зургийн уралдаан зарлаж, түрүүлсэн хэлтэст ТАЛАРХАЛ гардуулан ажилласан. Бүтээлд ирүүлсэн зургуудыг ханын самбарт нэмж байршуулсан. **Хавсралт 8**
8	Төрийн албаны зөвлөлөөс Ёс зүйн сургалт авах	Сургалтын тоо	2025 оны 06 дугаар сарын байдлаар ТАСЗ-өөс "Төрийн албан хаагчийн ёс зүй" сэдэвт 1 сургалт авсан. **Хавсралт 9** Төрийн албан хаагчийн баримтлах ёс зүйн тухай мэдээлэл цахим хэрэгслээр 2 мэдээлэл бэлтгэн олон нийтэд хүргэсэн. **Хавсралт 10** "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд хүлээлгэх хариуцлага сэдэвт" сургалт албан хаагчдад хүргүүлсэн. **Хавсралт 11** "Ёс зүйн тухай хуулиар ёс зүйн зөрчил гэж юу вэ" сэдэвт танилцуулга хүргүүлсэн. **Хавсралт 12**
9	Ёс зүйтэй Төрийн албан хаагч шалгаруулах	Арга хэмжээний тоо	Ёс зүйтэй Төрийн албан хаагчийн 2025 оны 12 сард шалгаруулахаар ажиллаж байна.
			Төрийн албан хаагчийн ёс зүйтэй холбоотой мэдээлэл танилцуулгыг 1 удаа и-оффисоор

10	Төрийн албан хаагчийн ёс зүй сэдэвт мэдээлэл хүргэх	Мэдээллийн тоо	хүргүүлсэн. Мөн шинээр томилогдсон албан хаагчдад Ёс зүйн тухай сургалт орж, Ёс зүйтэй төрийн албан хаагч байхаа баталсан БАТАЛГАА гардуулан өгч ажилласан. **Хавсралт 13**
11	Албан хаагчид дунд ёс зүйн зөрчилд өртөх эрсдэл байгаа эсэх судалгаа хийх	Судалгааны тоо	Байгууллагын нийт 13 албан хаагчаас Ёс зүйн зөрчилд өртөх эрсдлийн судалгаа хийв. **Хавсралт 14** Мөн нийт 18 албан хаагчаас Ёс зүйн нөлөөллийн мэдүүлэг авч баталгаажуулав. **Хавсралт 15**

ТАЙЛАН ГАРГАСАН:

Ёс зүйн дэд хорооны нарийн бичиг ..... Б.Хонгорзул

ТАЙЛАН ХЯНАСАН:

Ёс зүйн дэд хорооны дарга ..... Л.Эрдэнээ

Ёс зүйн хорооны 2025 оны ... дүгээр
сарын ...-ний өдрийн ... дугаар тогтоолын
гуравдугаар хавсралт

БАЙГУУЛЛАГЫН 2025 ОНЫ ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН "ТАЙЛАНГИЙН МАЯГТ"[1]

НЭГ. Товч танилцуулга[2]
Сүхбаатар аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Ёс зүйн дэд хороо 2024 оны 09 дүгээр сарын 09-ний өдөр шинэчлэн зохион байгуулагдаж хамт олны хуралдааны саналаар Газар, геодези, зураг зүйн хяналтын улсын байцаагч Б.Хүрэлбаатар, Барилга, хот байгуулалтын хэлтсийн дарга С.Наранчулуун, Захиргаа, хуулийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн Э.Болормаа нар байгууллагын ёс зүйн дэд хорооны гишүүнээр сонгогдсон. Сүхбаатар аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын даргын 2024 оны 09 дүгээр сарын 09-ний өдрийн А/90 дугаартай "Ёс зүйн дэд хороо байгуулах тухай " тушаалаар Газар, геодези, зураг зүйн хяналтын улсын байцаагч Б.Хүрэлбаатар дэд хорооны даргаар, Захиргаа, хуулийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн Э.Болормаа нарийн бичгийн даргаар томилогдсон. 2025 оны 12 дугаар сард нарийн бичгийн даргаар ажиллаж байсан Захиргаа, хуулийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн Э.Болормаа өөр ажилд шилжин томилогдсонтой холбогдуулан Ёс зүйн дэд хорооны гишүүнийг нөхөн томилохоор ажиллаж байна.
ХОЁР. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар
2.1.Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт[3]:
Монгол Улсын Их Хурлын 2024 оны 27 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 2025 оны 02 дугаар сарын 14-ний өдөр байгууллагын удирдлага, хэлтсийн дарга, төрийн албан хаагчидтай 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө байгуулахдаа Төрийн албаны тухай хууль, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг нарийн чанд баримтлаж ажиллах, хандлага, ёс зүй, ур чадвараа сайжруулах талаар нэмэлт үүрэг даалгаварыг албан хаагч тус бүрийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд нэмэлтээр тусгай заалт оруулж батлуулсан. Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль зүйн хэлтсээс албан хаагч нартаа "Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль"-ийн сургалт, Ёс зүйн академийн ерөнхийлөгч Ж.Оймандахыг урин "Ёс зүйг урлах соёл", Төрийн албан хаагчийн ёс зүйн манлайлал зэрэг сэдвүүдээр академик сургалт, 2025 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр "Ёс зүйн манлайлал, Хувь хүний хөгжил" нэртэй ахисан түвшний 4 удаагийн сургалтад албан хаагчидаа бүрэн хамруулж сертификат олгуулсан.
2.2.Томилох эрх бүхий албан тушаалтны ёс зүйн манлайлал:
Сүхбаатар аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын даргын зүгээс байгууллагын албан хаагчдын ёс зүйн асуудал, төрийн албан хаагчийн ёс зүйн манлайлалын асуудалд онцгой анхааран ажиллаж Ёс зүйн академийн ерөнхийлөгч Ж.Оймандахыг урин "Ёс зүйг урлах соёл", Төрийн албан хаагчийн ёс зүйн манлайлал зэрэг сэдвүүдээр академик сургалтыг зохион байгуулах болон бусад үйл ажиллагааг дэмжин ажилласан.

[1] Маягтын дагуу тайланг 5 хуудаснаас ихгүй, товч үр дүнг нэгтгэн ирүүлнэ.

[2] Байгууллагын харьяа салбар, нэгжийн хэмжээнд Төрийн албан хаагчийн ёс зүйн нийтлэг хэм хэмжээг сахиулах, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, зөрчил гаргасан эсэхийг хянан шалгаж, дүгнэлт гаргах, төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд дүн шинжилгээ хийх байдлын талаар товч мэдээллийг тайлагнана.

[3] Улсын Их Хурлын 2024 оны 27 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх хүрээнд зохион байгуулсан үйл ажиллагааны талаар тайлагнана.

СҮХБААТАР АЙМГИЙН
ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА
ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗАР
22000 Баруун-Урт, Сүхбаатар аймаг
Утас, факс: 70518605, 70512605

2025.12.26 № 1/598

танай 2025.12.23-ны № 2/4046-т

ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ,
ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ЕРӨНХИЙ
ГАЗАРТ

Тус газрын Ёсзүйн дэд хорооны 2025 оны тайланг хүргүүлж байна. Хүлээн авч танилцана уу.

Хавсралт 8 хуудастай

ДАРГА Э.ТӨГӨЛДӨР

2.3. Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа:	
2025 оны жилийн эцсийн байдлаар байгууллагын Ёс зүйн дэд хороонд төрийн албан хаагчидтай 2 төрийн албан хаагчид холбогдох 2 гомдол мэдээллийг ирүүлснийг Ёс зүйн дэд хорооны гишүүд хянан , шалгаж 2025/01 дугаартай дүгнэлтийг гарган удирдах албан тушаалтанд танилцуулж тус газрын даргын 2025 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн Б/03, Б/03 дугаартай "Ёс зүйн хариуцлага хүлээлгэх " тушаалаар 2 албан хаагчид ёс зүйн сахилгын шийтгэл ноогдуулсан.	
Гарсан үр дүн, ололт амжилт:	Бэрхшээл:
Төрийн албан хаагчидтай байгуулах гүйцэтгэлийн төлөвлөгөөнд нэмэлт арга хэмжээний төрлөөр Төрийн албаны тухай хууль, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг нарийн чанд баримтлаж ажиллах, хандлага, ёс зүй, ур чадвараа сайжруулах талаар үүрэгжүүлснээр төрийн албан хаагчтай холбоотой гомдол дахин гараагүй. Ёс зүйн академийн ерөнхийлөгч Ж.Оймандахыг урин "Ёс зүйг урлах соёл", Төрийн албан хаагчийн ёс зүйн манлайлал зэрэг сэдвүүдээр академик сургалт, 2025 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр "Ёс зүйн манлайлал, Хувь хүний хөгжил" нэртэй ахисан түвшний 4 удаагийн сургалтад албан хаагчидаа бүрэн хамруулж сертификат олгуулсан.	Төрийн албан хаагчдын үйлдэл эс үйлдэхүй болгоныг иргэн, аж ахуйн нэгж байгууллага ёс зүйн зөрчил гэж харах явдал нь төрийн албан хаагчдын ажиллах нөхцөл нийгмийн баталгааны одоогийн нөхцөл байдалтай уялдахгүй байна.
Санал:	
Ёс зүйн дэд хорооны гишүүдийн урамшууллын асуудлыг шийдвэрлүүлэх.	

Шалгах хэсэг:

- ☐ "Ёс зүй, сахилга хариуцлагын үнэлгээний шалгуур үзүүлэлт"-ийн дагуу үнэлгээ хийсэн эсэх.
- ☐ Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтэд нийцүүлэн баталсан үйл ажиллагааны төлөвлөгөө хавсаргасан эсэх.
- ☐ Байгууллагын 2025 оны Ёс зүйн дэд хорооны хууль тогтоомжийн хэрэгжилтийн тайланг маягтын дагуу бүрэн тайлагнасан эсэх.

БАТАЛГААЖУУЛАЛТ:

Томилох эрх бүхий албан тушаалтан
Газрын дарга
/Албан тушаал/ */Гарын үсэг/* Э.ТӨГӨЛДӨР
/Гарын үсгийн тайлал/

Ёс зүйн дэд хорооны дарга
Газар, геодези, зураг зүйн
хяналтын улсын байцаагч
/Албан тушаал/ */Гарын үсэг/* Б.ХҮРЭЛБААТАР
/Гарын үсгийн тайлал/

Огноо: 2025 оны 12 дугаар сарын 26-ны өдөр

БАТЛАВ: ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ
ДАРГА Б.ХҮРЭЛБААТАР

ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ 2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

2025 оны 01 сарын 07-ны өдөр

Д/д	Хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Хариуцах албан хаагч
НЭГ. Төрийн албан хаагчдын баримтлах ёс зүйн хэм хэмжээг сахиулах, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулах чиг үүргийн хүрээнд:			
1.1	Ёс зүйн дэд хорооны бүрэлдэхүүн хуралдаж, 2025 оны төлөвлөгөөг хэлэлцэж, батлуулах	2025 оны 01-р сарын 07-ны өдөр	Гишүүд
1.2	"Төрийн албан хаагчийн ёс зүй" сэдэвт сургалт зохион байгуулж, ёс зүйн дүрэм, журмыг танилцуулах	2025 оны 4-р сард	Э.Болормаа
1.3	Шинээр томилогдсон албан хаагчид ёс зүйн зөвөлгөө өгч, мэдээллээр ханган ажиллах	Тухай бүр	Э.Болормаа
1.4	Албаны үйл ажиллагаа, албан хаагч нарын харилцааны соёл, ёс зүйн алдаа дутагдлыг илрүүлэх судалгаа хийх	2025 оны 7-р сард	С.Наранчулуун
1.5	Ажлын байрны бэлгийн дарамтын тухай мэдээллийг албан хаагчдад хүргэж ажиллах, илрүүлэх судалгаа авах	2025 оны 04-р сард	Э.Болормаа
1.6	Ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр гарын авлага, зөвлөмж, уриалга боловсруулж түгээх, (постер, контент, подкаст)	2025 оны 05-р сард	Э.Болормаа
1.7	Төрийн албан хаагчийн ажил хэрэгч байдал, албан хувцаслалтын хэм хэмжээг хангуулах	2025 оны 03-р сард	Э.Болормаа
ХОЁР. Гомдол мэдээллийг хүлээн авч, шийдвэрлэх чиг үүргийн хүрээнд:			
2.1	Ёс зүйн зөрчлийн талаар гомдол мэдээллийг цаасаар болон цахимаар, харилцаа холбооны бүх хэлбэрээр хүлээн авах, зарим тохиолдолд зөрчлийг байгууллагын хяналт шалгалт, судалгааны үр дүнд илрүүлэх	Тухай бүр	Бүх гишүүд
2.2	Ёс зүйн зөрчлийн талаарх мэдээлэл, гомдлыг ёс зүйн	Тухай бүр	Бүх гишүүд

	зөвлөлийн хурлаар хэлэлцэж, дүгнэлт гаргах		
2.3	Ёс зүйн зөвлөлийн хурлын дүгнэлтийг албаны даргад танилцуулж, шийдвэрлүүлэх	Тухай бүр	Б.Хүрэлбаатар
ГУРАВ. Бусад ажлын чиглэлээр:			
3.1	Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил, Ёс зүйн зөвлөлийн төлөвлөгөөний биелэлийн мэдээ тайланг бүтэн жилээр гаргаж, холбогдох байгууллагад хүргүүлэх	4-р улиралд	Г.Хүрэлбаатар С.Наранчулуун Э.Болормаа
3.2	Гомдол, мэдээлэл, зөрчлийн шийдвэрлэлтийн талаарх хурлын тэмдэглэл, тогтоолын бүрдлийг хангаж архивийн нэгж үүсгэх	4-р улиралд	Э.Болормаа

ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛСАН: Ёс зүйн дэд хорооны Нарийн бичгийн дарга Э.Болормаа

СЭЛЭНГЭ АЙМГИЙН
ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА
ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗАР

Нутгийн захиргааны II байр, Орхон 6 дугаар баг,
Сүхбаатар сум, Сэлэнгэ аймаг, 43082,
Утас: 7036-3800, 7036-3562, 7036-2133, 7036-2022
Цахим шуудан: selenge@gazar.gov.mn
Цахим хуудас: www.selenge.gazar.gov.mn

2025.12.30 № 01/678

танай 2025.12.23 -ны № 2/4046. -т

ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ,
ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ЕРӨНХИЙ ГАЗАРТ

ГЗБГЗЗЕГ-аас ирүүлсэн 2025 оны 2/4046 дугаартай албан бичгийн дагуу тус газрын 2025 оны төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулсан тайланг хавсралтаар хүргүүлэв.

ДАРГА Б.САРУУЛТӨГС

1322020012 CTC3101 9057528

432500538

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН 2025 ОНЫ ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

НЭГ. Товч танилцуулга

Байгууллагын албан хаагчдын ёс зүйн нийтлэг хэм хэмжээг сахиулах хүрээнд ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, зөрчил гаргасан эсэхийг хянан шалгаж, дүгнэлт гаргах, төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд дүн шинжилгээ хийх чиг үүрэг бүхий байгууллагын "Ёс зүйн дэд хороо"-г Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Монгол улсын Ёс зүйн хорооны 2025 оны 05 дугаар тогтоолоор батлагдсан "Ёс зүйн дэд хорооны ажиллах журам"-ыг тус тус үндэслэн Газрын даргын 2025 оны А/04 дүгээр тушаалаар 5 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулан ажиллуулж байна.

ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ 2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Хэрэжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Хүрэх түвшин	Төсөв	Хугацаа	Хариуцлаг гишүүний нэр, албан тушаал хамтран ажиллах хэлтэс
1	2	3	4	5	6	7
Нэг. Зөвлөх байгууллагын үйл ажиллагааны талаар						
1	Ёс зүйн дэд хороо-ны 2025 оны хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулан Газрын даргаар батлуулан хэрэгжилтийг хангаж ажиллах	Арга зүйжсэний хэрэгжилтийн хувь	100 хувь	-	1-р улиралд	Ёс зүйн дэд хорооны нийт гишүүдийн
2	Ёс зүйн дэд хороо-ны төлөвлөгөөний биелэлтийг холтос Газрын даргад тайлагнах	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	100 хувь	-	Тухай бүр	Нарийн бичгийн дарга
3	Ёс зүйн зөрчилтэй талаарх мэдээ тайлан тухай бүр холбогдох дэд газрат хүргүүлэх ажиллагаа	Арга зүйжсэний хэрэгжилтийн хувь	100 хувь	-	Тухай бүр	Нарийн бичгийн дарга
4	Ёс зүйн дэд хороо-ны гишүүний гишүүнчлэлийг тухай бүр шийдэн зүтгүүлэх ажиллагаа	Арга зүйжсэний хэрэгжилтийн хувь	100 хувь	-	Тухай бүр	Нарийн бичгийн дарга
Хоёр. Ёс зүйн зөрчилтэй талаарх мэдээллийг хүлээн авч, хэлбэлзэх хүлээ тогтоомжийн хүрээнд хянуу арга хэмжээ авч ажиллах талаар						
5	Ажилтан, албан хаагчдын ёс зүйн зөрчил гарсасн тухай этгээд мэдээлэгч цаасан болон цахим хэлбэрээр хүлээн авч хянан шийдвэрлэх хүрэлцээнд тухай бүрд нь зохион байгуулах	Арга зүйжсэний хэрэгжилтийн хувь	100 хувь	-	Тухай бүр	Нарийн бичгийн дарга
6	Ёс зүйн зөрчил гаргасан тухай этгээдэд мэдээллийн үндэслэлийг шалган тогтоох, хууль тогтоомж, дүрэм журмыг хүрээнд дэлгэрэнгүй гаргах, дүгнэлтийг холбогдох газар, албан тушаалтанд хүргүүлэх	Арга зүйжсэний хэрэгжилтийн хувь	100 хувь	-	Тухай бүр	Нарийн бичгийн дарга
7	Ёс зүйн зөрчлөөтэй хүлээсэн төрийн албан хаагчийг танилцуулж болсон цагаас сурвалжлах хэмжүүлэх	Арга зүйжсэний хэрэгжилтийн хувь	100 хувь	-	Тухай бүр	Ёс зүйн дэд хорооны нийт гишүүдээрээ

Тус хороо нь байгууллагын албан хаагчдын Төрийн албаны тухай хууль, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Монгол улсын Ёс зүйн хорооны 2025 оны 05 дугаар тогтоолоор батлагдсан "Ёс зүйн дэд хорооны ажиллах журам"-д нийцүүлэн байгууллагын Ёс зүйн дэд хорооны 2025 оны үйл ажиллагааны 3 үндсэн зорилт 12 арга хэмжээ бүхий төлөвлөгөөг боловсруулан баталж, хэрэгжилтийг ханган ажиллав.

ХОЁР. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар

2.1. Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт:

Ёс зүйн дэд хорооны 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгасан "Сургалт, соён гэгээрүүлэх урьдчилсан сэргийлэх үйл ажиллагааны талаар" зорилтын хүрээд дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэн ажиллав. Үүнд:

1. "Шинээр томилогдсон ажилтан, албан хаагчдад Газрын "Ёс зүйн дүрэм"-ийг танилцуулж, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалтанд хамруулах" арга хэмжээнийн хүрээнд шинээр томилогдсон 6 албан хаагчид Төрийн албаны тухай хууль, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль болон байгууллагын Хөдөлмөрийн дотоод журмуудыг танилцуулж, дээрх хууль журмыг мөрдөж ажиллахыг чиглэл болгов.

2. "Төрийн албан хааагчийн ёс зүйн тухай хууль болон холбогдох дүрэм, журмын талаар танилцуулга, мэдээлэл бэлтгэж Газрын дотоод сүлжээ, мэдээллийн самбарт байршуулж сурталчлах, мэдээлэх" арга хэмжээний хүрээнд нийт албан хаагчдад танхимын сургалтад 1 удаа хамруулж, шаардлагатай мэдээ, зөвлөгөөг бэлтгэн байгууллагын дотоод сүлжээнд байршуулж ажиллав.

3. "Газрын нийт албан хаагчдад "Ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалт"-ыг 2-оос доошгүй удаа зохион байгуулах" арга хэмжээний хүрээнд байгууллагын албан хаагчдыг чадавхжуулах, хууль тогтоомжийн хэрэглээг зөв

ойлгон хэрэгжүүлэхэд анхаарах, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулиудыг хэрэгжүүлэх зорилгоор дараах сургалтуудад албан хаагчдыг хамруулж ажиллав. Үүнд:



Байгууллагын Ёс зүйн дэд хороо, Гадаадын иргэн харьяатын газрын Хойд бүс дэх газар болон лектор Чила буюу н.Бандицэрэнтэй хамтран "Эерэг сэтгэл зүй" сэдэвт сургалтыг 2025 оны 02 дугаар сарын 18-ны өдөр зохион байгуулж, 12 албан хаагчийг хамруулав.

"Захиргааны шийдвэр гаргах, хууль тогтоомжийн хэрэглээ" сэдэвт сургалтыг Удирдлагын академийн багш доктор Алтанзулаас 2025 оны 02 дугаар сарын 24-ний өдөр танхимын болон цахим хэлбэрээр нийт 30 албан хаагчийг хамруулав.

4. "Ёс зүйн зөрчлийн хянан шийдвэрлэх чиглэлийн сургалтад Ёс зүйн дэд хорооны гишүүдийг хамруулах" арга хэмжээний хүрээнд аймгийн ЗДТГ-аас зохион байгуулсан танхимын сургалтад Ёс зүйн дэд хорооны 5 гишүүнийг хамруулсан.

2.2. Томилох эрх бүхий албан тушаалтны ёс зүйн манлайлал:

Тайлант хугацаанд тус газрын томилох эрх бүхий албан тушаалтан төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомжийг чанд мөрдөн, ёс зүйтэй, ил тод, шударга харилцаа, хандлагаар албан хаагчийг үлгэрлэн манлайлах соёлыг төлөвшүүлж ажилласан бөгөөд, энэ төрлийн зөрчлийг гаргаагүй байна.

Мөн байгууллагын үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүнг жил бүр www.selenge.gazar.gov.mn вэб хуудсанд байршуулж, олон нийтэд мэдээлж ажиллаж байна.

2.3. Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа:

Байгууллагын Ёс зүйн дэд хороо нь байгууллагын албан хаагчдын Төрийн албаны тухай хууль, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Монгол улсын Ёс зүйн хорооны 2025 оны 05 дугаар тогтоолоор батлагдсан "Ёс зүйн дэд хорооны ажиллах журам"-д нийцүүлэн байгууллагын Ёс зүйн дэд хорооны 2025 оны үйл ажиллагааны 3 үндсэн зорилт 12 арга хэмжээ бүхий төлөвлөгөөг боловсруулан баталж, хэрэгжилтийг ханган ажиллав.

Гарсан үр дүн, ололт амжилт:	*Бэрхшээл:*
✓ Албан хаагчдын Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, дүрэм болон ёс зүйн талаарх мэдлэг, хариуцлага дээшилсэн.	✓ Ёс зүйн дэд хорооны гишүүд үндсэн ажлынхаа хажуугаар үүрэг гүйцэтгэдэг тул ёс зүйн асуудалд зарцуулах цаг, боломж хязгаарлагдмал байна. ✓ Ес зүйн сурталчилгааны сургалт, мэдээлэл, ажлыг тогтмол, тасралтгүй зохион байгуулахад санхүү, зохион байгуулалтын хүндрэл тулгарч байна.

Санал:

- ✓ Ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалт нөлөөллийн өдөрлөг, үйл ажиллагааг албан хаагчдад түгээх ажилд дэмжиг үзүүлэх гарын авлага хангах
- ✓ Албан хаагчдад "Ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх соён гэгээрүүлэх сургалт"-ыг *зохион байгуулах үйл ажиллагааг дэмжих*
- ✓ Ёс зүйн зөрчлийн хянан шийдвэрлэх чиглэлийн сургалтанд "Ёс зүйн дэд" хорооны гишүүдийг хамруулах санхүүнийн дэмжлэг шийдвэрлүүлэх

БАТАЛГААЖУУЛАЛТ:

Томилох эрх бүхий албан тушаалтан
Газрын дарга /Б.САРУУЛТӨГС/

Ёс зүйн дэд хорооны дарга
Барилга, хот байгуулалтын хэлтсийн дарга /Ч.ДОРЖМЯГМАР/

Ёс зүйн дэд хорооны нарийн бичгийн дарга
Захиргаа, хуулийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн /Ж.НОМИН-ЭРДЭНЭ/

2025 оны 12 дугаар сарын 30-ны өдөр

УВС АЙМАГ
ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА
ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗАР

Улаангом, Увс аймаг, 85160
Утас: 7045-4830, Факс: 7045-3122
Цахим шуудан: uvs@gazar.gov.mn
Цахим хуудас: www.uvs.gazar.gov.mn

2025.01.06 № 04

танай 2025.12.23 -ны № 1/4046 -т

ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ,
ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ЕРӨНХИЙ ГАЗАРТ

Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн тайланг батлагдсан шалгуур үзүүлэлтийн дагуу боловсруулан хүргүүлэв.

Хавсралт 5 хуудастай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Б.БАТ-ЕРӨӨЛТ

8526140005

ТӨЛӨВЛӨГӨӨГ БАТАЛСАН: ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ
ДАРГА Ж.ЖИГЖИДСҮРЭН

УВС АЙМГИЙН ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН 2025 ОНД ХИЙХ ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

1. Нийт албан хаагчдад байгууллагын ёс зүйн талаар сургалт мэдээлэл хийх.
2. Гомдол мэдээлэл, илэрсэн зөрчлийг тухай бүрд нь шийдвэрлэж, тайлан мэдээг хугацаанд нь хүргүүлэх.
3. Ёс зүйн тухай хууль, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар байгууллагын дотоод сүлжээнд постер, зөвлөмж, мэдээллийг тогтмол байршуулж соён гэгээрүүлэх ажлыг хийх.
4. Байгууллагын нийт албан хаагчдад хөгжөөнт асуулт хариултын тэмцээн зохион байгуулах/Төрийн албаны тухай, Ёс зүйн тухай хууль, холбогдох хууль, дүрэм журам, хөгжөөнт асуулт/
5. Талархлын арга хэмжээ зохион байгуулж нийт албан хаагчдад эрэг хандлага, харилцааг нэмэгдүүлэх.

Төлөвлөгөөг гаргасан:
Ёс зүйн дэд хорооны нарийн бичгийн дарга /Ц.Болормаа/

Төлөвлөгөөг хянасан:
Ёс зүйн дэд хорооны дарга /Ж.Жигжидсүрэн/

УВС АЙМГИЙН ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН 2025 ОНЫ ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

Нэг. Товч танилцуулга
Увс аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын ёс зүйн дэд хороог нийт албан хаагчдын санал асуулгаар 5 гишүүнийг сонгож 2024 оны 10 сарын 29 өдрийн А/30 дугаартай даргын тушаалаар баталж байгуулсан байна.
Хоёр. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар
2.1. Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт:
Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн хүрээнд байгууллагын Ёс зүйн дэд хорооны 2025 оны төлөвлөгөөг бүрэн нийцүүлж гаргаагүй байна. Соён гэгээрүүлэх, сургалт нөлөөллийн ажлын хүрээнд ёс зүйн сургалтыг 2 удаа батлагдсан агуулгын хүрээнд зохион байгуулсан, "Ёс зүйтэй төрийн албан хаагч 7 хоногийн аян"-ы ажлын төлөвлөгөөг боловсруулан зохион байгуулсан байна.
2.2. Томилох эрх бүхий албан тушаалтны ёс зүйн мэдлэйлал:
Ёс зүйн дэд хороонд 2025 онд гомдол ирээгүй тул дүгнэлт гаргаагүй, Ёс зүйн дэд хорооны гишүүдийн урамшууллыг хууль тогтоомжийн хүрээнд олгосон байна.
2.3. Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа:
1. Сумдын даамлуудын нэгдсэн сургалтаар аймгийн Цагдаагийн газрын сэтгэл зүйчээр ажлын байрны стрессээс ангижрах талаар сургалт, байгууллагын нийт ажилчдын дунд аймгийн Төрийн захиргаа удирдлагын хэлтсийн дарга төрийн албан хаагчийн ёс зүй сэдэвт сургалтыг тус тус хийсэн байна. 2. Энэ онд гомдол мэдээлэл ирээгүй, тайлан мэдээг улирал, хагас жилээр нь аймгийн Засаг даргын тамгын газарт хүргүүлсэн. 3.Байгууллагын ёс зүй, соёлын талаар дотоод сүлжээнд албан хаагчдад постерыг суртчилж, түгээсэн. 4. Байгууллагын нийт албан хаагчдад хөгжөөнт асуулт хариултын тэмцээн зохион байгуулахаар 1 дүгээр улиралд төлөвлөсөн боловч нийт даамлууд, албан хаагчдын сургалтын хөтөлбөрт цаг нь багтаагүй тул тухайн ажил хийгдээгүй байна. 5. Ёс зүйтэй төрийн албан хаагч 7 хоногийн аянг төлөвлөгөө гаргаж хэрэгжүүлсэн. Үүнд: • Дархлаажуулалтын аян- байгууллагын албан хаагчдад витамин, жимсний шүүс, вакус зэрэг бүтээгдэхүүнүүдийг сугалаагаар татуулж албан хаагчдад олгосон. • Бага үдийн цай- аарц, чацарганы шүүс, хөнгөн зууш • Байгууллагын спорт зааланд тоглох өдөр цэвэр ус, вакусыг тус тус ёс зүйн дэд хорооны гишүүдээс өгсөн.

• Ёс зүйн дэд хорооны гишүүдийн саналаар ёс зүйтэй төрийн албан хаагчийг шалгаруулан дурсгалын зүйлээр шагнасан. • Ёс зүйтэй төрийн албан хаагч 7 хоногийн аяны хүрээнд талархлын хайрцаг аялуулан албан хаагчдын дунд эерэг сэтгэгдлүүдийг хайрцагт цуглуулан тухайн албан хаагч тус бүрт хүргүүлсэн, хамгийн их эерэг сэтгэгдэл авсан албан хаагчийг ёс зүйтэй албан хаагчаар тодруулан дурсгалын зүйлээр шагнав.	
Гарсан үр дүн, ололт амжилт:	Бэрхшээл
Байгууллагын албан хаагчдад ёс зүйтэй төрийн албан хаагчийн 7 хоногийн аянг хэрэгжүүлснээр албан хаагчдын дунд эерэг сэтгэгдлийг төрүүлсэн байна.	Одоогийн байдлаар бэрхшээл асуудал үүсээгүй байна.
Санал	
Ёс зүйн хорооноос гарч байгаа тушаал шийдвэрийг тухай бүрд нь Ёс зүйн дэд хороодод танилцуулж, мэдээллээр хангаж байх.	

Шалгах

☑ "Ёс зүй, сахилга хариуцлагын үнэлгээний шалгуур үзүүлэлт"-ийн дагуу үнэлгээ хийсэн эсэх.

☐ Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтэд нийцүүлэн баталсан үйл ажиллагааны төлөвлөгөө хавсаргасан эсэх.

☑- Байгууллагын 2025 оны Ёс зүйн дэд хорооны хууль тогтоомжийн хэрэгжилтийн тайланг маягтын дагуу бүрэн тайлагнасан эсэх.

БАТАЛГААЖУУЛАЛТ:

Томилох эрх бүхий албан тушаалтан:

ДАРГА ..... Б.БАТ-ЕРӨӨЛТ

/Албан тушаал/ /Гарын үсэг/ /Гарын үсгийн тайлал/

Ёс зүйн дэд хорооны дарга:

БТХУАБАЙЦААГЧ ..... Ж.ЖИГЖИДСҮРЭН

/Албан тушаал/ /Гарын үсэг/ /Гарын үсгийн тайлал/

Ёс зүйн дэд хорооны нарын бичгийн дарга:

НЯГТЛАН БОДОГЧ	.....	Ц.БОЛОРМАА
/Албан тушаал/	/Гарын үсэг/	/Гарын үсгийн тайлал/

ХОВД АЙМАГ
ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА
ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗАР

84140 Ховд,Жаргалант сум, Ховд аймаг
Утас/Факс: (+976)7043-4019
Цахим шуудан:khovd@gazar.gov.mn
Цахим хуудас: www.khovd.gazar.gov.mn

2025.12.31 № 744

танай 2025.12.23-ны № 2/4046 -т

ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ГАЗРЫН ДАРГА Б.ЭНХБОЛД ТАНАА

Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн тайланг батлагдсан шалгуур үзүүлэлт, маягтын дагуу гарган хүргүүлж байна.

Хавсралт 3 хуудастай.

ДАРГА Б.ШИНЭЗОРИГ

3068805 1623100027

Ёс зүйн хорооны 2025 оны 12 дугаар
сарын 01-ний өдрийн 09 дүгээр тогтоолын
гуравдугаар хавсралт

АЛБАН БАЙГУУЛЛАГЫН 2025 ОНЫ ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН "ТАЙЛАНГИЙН МАЯГТ"

Нэг. Товч танилцуулга

Ховд аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын даргын 2025 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн А/19 дүгээр "Ёс зүйн дэд хороо байгуулах тухай" тушаалаар баталсан. Албан байгууллагын 2025 оны ёс зүйн дэд хороонд Инженерийн дэд бүтцийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн, Газрын удирдлагын хэлтсийн дарга, Захиргаа, хуулийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн, Барилгын асуудал хариуцсан мэргэжилтэн, Албан хэрэг хөтлөлт, хариуцсан ажилтан зэрэг төрийн захиргааны болон үйлчилгээний албан тушаалтанууд томилогдон ажиллаж байна.

Хоёр. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар

2.1. Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт

Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Монгол Улсын Их Хурлын 2024 оны 27 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт, Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 109 дүгээр "Ес зүйн хэм хэмжээ батлах тухай" тогтоолуудыг хэрэгжүүлэн ажиллаж байна. Төрийн бодлогын залгамж чанар, тогтвортой байдлыг хангаж, салбарын удирдлагын манлайллыг мэргэжлийн түвшинд хариуцлагатай хэрэгжүүлж, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг чанд сахиж, мөрдлөг болгон хэрэгжүүлэн ажиллаж байна. Төрийн албаны зөвлөлийн Ховд аймаг дахь салбар зөвлөлийн дарга Б.Ганболд төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулиар, Ховд аймгийн Цагдаагийн газраас гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулиар, Ховд аймгийн шүүхийн тамгын газраас Монгол улсын Эрүүгийн хуулийн Тусгай ангийн хорин хоёр дугаар бүлгийн авлигын гэмт хэргийн талаархи сургалт, Аймгийн Засаг даргын Тамгын газрын хууль эрх зүйн хэлтэсээс нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, хөдөлмөрийн тухай хууль, захирамж, тушаалын төсөл бэлтгэхэд анхаарах асуудал сэдвээр зөвлөмж бэлтгэх сургалт, Ховд аймгийн прокурорын газраас Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулах журам, эрх хязгаарлах арга хэмжээ авах журам, Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулах үндэслэл журам, шийтгэл оногдуулах үндэслэл, анхаарах асуудал" сэдвээр сургалт, Хүний эрхийн үндэсний комиссын Ховд аймаг дахь референт М.Өнөрмаа, Хүүдийн элч, хүүхэд хамгаалагч М.Оюунсүрэн нар хамтран Хүний эрхийн үндсэн ойлголт, хандлага, Жендэрийн тухай ойлголт, Эцэг эхийн үүрэг хариуцлага сэдэвт сургалтуудыг зохион байгуулсан. Ес зүйн нөлөөллийн мэдүүлэг, Ес зүйн зөрчлийн хариуцлагын бүртгэлийн маягтуудыг бөглөн ажиллаж байна.

2.2. Томилох эрх бүхий албан тушаалтны ёс зүйн манлайлал:

Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газарт Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа гишүүдийг урамшуулах санхүүгийн эх үүсвэрийг

шийдвэрлэхээр 2025 оны 06 дугаар сарын 02-ны өдөр 308 дугаар албан бичгээр 2026 оны төсвийн төсөөлөлд тусгуулахаар хүргүүлсэн. Төрийн албаны тухай хууль, төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, төрийн захиргааны болон үйлчилгээний албан тушаалд эрхэлдэг төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээний хэрэгжилтийг хангуулан үйл ажиллагааны тайлан, зөрчлийн шийдвэрлэлтийг цахим хуудсанд байршуулан ажиллаж байна.
2.3. Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа:
Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Монгол Улсын Их Хурлын 2024 оны 27 дугаар тогтоолоор батлсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт, Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 109 дүгээр "Ес зүйн хэм хэмжээ батлах тухай" тогтоолуудыг хэрэгжүүлэн ажиллаж байна. Төрийн албаны тухай хууль, төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, төрийн захиргааны болон үйлчилгээний албан тушаалд эрхэлдэг төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээний хэрэгжилтийг хангуулан ажлын төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг хийж хэрэгжүүлж, төлөвлөгөөний биелэлтийг тооцсон. Дэд хорооны бүрэлдэхүүн хөдөлгөөнийг бүртгэж, төрийн албан хаагчаас ирүүлсэн гомдол, мэдээллийг шийдвэрлэж, ёс зүйн зөрчлийн бүртгэл, хяналтын дэд систем дэх дүгнэлт, шийдвэрийг бүртгэж, тайлагнан ажиллаж байна. Мөн төрийн албан хаагчдын ёс зүй, харилцаа хандлагатай холбоотой 5 өргөдөл, хүсэлтийг хүлээн авч, албан хаагчдаас холбогдох тайлбарыг авч, ёс зүйн дэд хороогоор хэлэлцүүлэн дүгнэлт гаргасан.

Гарсан үр дүн, ололт амжилт:	***Бэрхшээл:***
Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Монгол Улсын Их Хурлын 2024 оны 27 дугаар тогтоолоор батлсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт, Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 109 дүгээр "Ес зүйн хэм хэмжээ батлах тухай" тогтоолуудыг албан байгууллагын төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчдад танилцуулах хуудсаар танилцуулсан.	-

Санал:
-

Шалгах хэсэг:

- "Ёс зүй, сахилга хариуцлагын үнэлгээний шалгуур үзүүлэлт"-ийн дагуу үнэлгээ хийсэн эсэх
- Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтэд нийцүүлэн баталсан үйл ажиллагааны төлөвлөгөө хавсаргасан эсэх.
- Байгууллагын 2025 оны Ёс зүйн дэд хорооны хууль тогтоомжийн хэрэгжилтийн тайланг маягтын дагуу бүрэн тайлагнасан эсэх.

БАТАЛГААЖУУЛАЛТ:

Томилох эрх бүхий албан тушаалтан

Газрын дарга ..... Б. Шинэдорж

/Албан тушаал/ /Гарын үсэг/ /Гарын үсгийн тайлал/

Ёс зүйн дэд хорооны дарга

Тухайтын дарга ..... Э. Цогтсайхан

/Албан тушаал/ /Гарын үсэг/ /Гарын үсгийн тайлал/

Ёс зүйн дэд хорооны нарийн бичгийн дарга:

Ахлах ажил ..... Б. Буянмөнх

/Албан тушаал/ /Гарын үсэг/ /Гарын үсгийн тайлал/

Огноо. 2025 оны 12 дугаар сарын 30

ХЭНТИЙ АЙМГИЙН
ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА,
ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗАР

Тэмүүжингийн гудамж, Л-39 дүгээр байр, Хэрлэн баг
Хэрлэн сум, Хэнтий аймаг, 23123, Утас/Факс: (976) 70563010
Цахим шуудан: khentii@gazar.gov.mn
Цахим хуудас: khentii.gazar.gov.mn

2025.12.30 № 01/862

танай 2025.12.23 -ны № 2/4046 -т

ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ГЕОДЕЗИ,
ЗУРАГ ЗҮЙН ЕРӨНХИЙ ГАЗАРТ

Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн тайланг батлагдсан шалгуур үзүүлэлт, маягтын дагуу гарган хүргүүлэв.

Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтэд нийцүүлэн баталсан үйл ажиллагааны төлөвлөгөөг Ёс зүйн зөрчлийн бүртгэл, хяналтын дэд системд оруулан баталж, биелэлтийг тайлагнасан болно.

Хавсралт 4 хуудастай.

ДАРГА Б.СҮНГЭЭ

1819100002
ИМТ1449 4186192

D:\БИЧИГ ХЭРЭГ-2025\А5 ТООТ\

БАЙГУУЛЛАГЫН 2025 ОНЫ ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН "ТАЙЛАНГИЙН МАЯГТ

НЭГ. Товч танилцуулга
Газрын даргын 2025 оны 01 дүгээр сарын 15-ний өдрийн А/04 дүгээр тушаалаар байгууллагын Ёс зүйн дэд хороог байгуулсан. Ёс зүйн дэд хорооны даргаар Барилга, хот байгуулалтын хэлтсийн дарга М.Хишигбаяр, гишүүд Ерөнхий нягтлан бодогч Д.Ганзул, Газар зохион байгуулалт, төлөвлөлт, газар өмчлөлийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн Г.Банзрагч, Лабораторийн шинжээч Б.Болорцэцэг, Захиргаа, хуулийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн тус тус ажиллаж байна.
ХОЁР. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар
2.1. Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт:
"Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцоо" цахим системд сахилгын шийтгэл ногдуулсан талаарх бүртгэлийг тогтмол хийн ажилласан. Ёс зүйн зөрчилд хариуцлага тооцсон талаарх мэдээллийг байгууллагын албан хаагчдын дотоод цахим хаягт мэдээлж, хяналт тавих боломжийг бүрдүүлсэн. 2025 онд төрийн албанд анх томилогдсон 8 албан хаагчдыг ёс зүйн чиглүүлэх сургалтад хамруулсан. 2025 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн Хэнтий аймаг дахь Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн 10, 24, 25, 26, 27 дугаар тус тус тогтоолыг үндэслэн Төрийн албаны тусгай шалгалт өгөх болзол журмын хүрээнд 5 албан хаагч, 2025 оны 08 дугаар сарын 28-ны өдөр төрийн албан хаагчийг сэлгэн шилжин ажиллуулах зарыг байгууллагын цахим хуудсанд байршуулан “Төрийн жинхэнэ албан хаагчийг өөр албан тушаалд шилжүүлэх, сэлгэн ажиллуулах журам”-ын хүрээнд албан тушаалын адил ангилал зэрэглэлд 2 албан хаагчийг ёс зүйн нийтлэг шаардлагад нийцүүлэн тус тус томилсон.
2.2. Томилох эрх бүхий албан тушаалтны ёс зүйн манлайлал:
Ёс зүйн дэд хорооны нарийн бичгийн даргад хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 50 хувьтай тэнцэх хэмжээний урамшууллыг сар бүр, дарга, гишүүдэд хурал болон бусад арга хэмжээнд оролцсон ирц, идэвх оролцоог харгалзан хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр тооцож, улиралд нэг удаа олгох урамшууллыг цалингийн зардлаас гарган Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа, гишүүдийг урамшуулах санхүүгийн эх үүсвэрийг шийдвэрлэж ажилласан. Ёс зүйн дэд хорооны дүгнэлтэд үндэслэж, зөрчил гаргасан этгээдэд зөрчлийн шинж байдалд нийцүүлэн хариуцлага хүлээлгэсэн. Мөн томилох эрх бүхий албан тушаалтан сахилгын болон ёс зүйн зөрчил гаргасан тохиолдол байхгүй болно.
2.3. Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа:

Салбарын хэмжээнд ёс зүйн зөрчил, үүрэг хариуцлага, ажлын цаг ашиглалттай холбоотой 1 гомдолд дүгнэлт гарган ажилласан. 2025 онд шинээр томилогдсон алба хаагчдад байгууллагын ёс зүйн дүрмийг танилцуулж, гарын үсэг зуруулан баталгаажуулж ажилласан. Байгууллагын ёс зүйн дэд хорооны өргөдөл гомдол хүлээн авах цахим KhentiiGHBHBGEszuindedhoroo@gmail.com хаяг нээж байгууллагын page хуудсанд байршуулан мэдээллэсэн. 2025 оны 08 дугаар сард Хүний эрхийн үндэсний комиссын Хэнтий аймаг дахь Референт Ж.Ганбаяртай хамтран Төрийн албан хаагчийн ёс зүй болон Хүний эрхийн талаарх сургалтыг зохион байгуулж, байгууллагын нийт албан хаагчдыг хамруулсан.	
Гарсан үр дүн, ололт амжилт:	Бэрхшээл:
2025 оны байдлаар ёс зүйн талаарх гомдол мэдээлэл буурсан байна.	Байхгүй.
Санал:	
Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд энэ оны 10 дугаар сараас эхлэн ёс зүйн дэд хорооны гишүүдэд олгох нэмэгдлийг хассан тул цаашид урамшууллыг Ёс зүйн тухай хуулийн дагуу шийдвэрлүүлэх саналтай байна.	

Шалгах хэсэг:

- ✓ "Ёс зүй, сахилга хариуцлагын үнэлгээний шалгуур үзүүлэлт"-ийн дагуу үнэлгээ хийсэн эсэх.
- ✓ Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтэд нийцүүлэн баталсан үйл ажиллагааны төлөвлөгөө хавсаргасан эсэх.
- ✓ Байгууллагын 2025 оны ЁС зүйн дэд хорооны хууль тогтоомжийн хэрэгжилтийн тайланг маягтын дагуу бүрэн тайлагнасан эсэх.

БАТАЛГААЖУУЛАЛТ:

Томилох эрх бүхий албан тушаалтан

Газрын дарга /......./ *Б.Сүнгээ*

ЁС зүйн дэд хорооны дарга

Барилга, хот байгуулалтын хэлтсийн дарга /.....М.Хишигбаяр/ *М.Хишигбаяр*

Ёс зүйн дэд хорооны нарийн бичгийн дарга

Лабораторийн шинжээч /.....Б.Болорцэцэг/ *Б.Болорцэцэг*

2025 оны 12-р сарын 30-ны өдөр